



Б.АРИУНЗАЯА



Х.ГҮНБИЛИГТ



УБАДАМСҮРЭН



Ц.САРМАНДАХ



Б.ХУЛАН



Г.ДОРЖБАЛАМ

“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖ, ТУЛГАМДАЖ БУИ АСУУДЛУУД”



Фридрих-Эбертийн сангийн
2022-2023 оны тэтгэлэгт оюутнуудын судалгааны тайлан

Улаанбаатар хот
2023 он



ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Фридрих-Эбертийн сангийн 2022-2023 оны тэтгэлэгт оюутнуудын судалгааны тайлан

Энэхүү судалгааны аливаа агуулга, мэдээллийн үнэн зөвийг судлаачид хариуцах бөгөөд Фридрих-Эбертийн сангийн байр суурьд нийцэж байх албагүй болно.

Судалгааг хийж гүйцэтгэсэн:

Б.Ариунзаяа
У.Бадамсүрэн
Х.Гүнбилигт
Г.Доржбалам
Ц.Саранмандах
Б.Хулан

Зөвлөх багш:

Доктор, дэд профессор Б.Хишигням

Эхийг бэлтгэсэн:

Ё.Батболд

“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД”

Фридрих-Эбертийн сангийн 2022-2023 оны
тэтгэлэгт оюутнуудын судалгааны тайлан

Улаанбаатар хот

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт	5
Зургийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт	6
УДИРТГАЛ	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААРХ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	11
1.1 Нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ	12
1.2 Цахим хичээлийн хүртээмжтэй байдал	12
1.3 Орон нутаг дахь их, дээд сургуулийн хүртээмжтэй байдал	13
1.4 Жендэрийн тэгш байдал	14
1.5 Эрх зүйн зохицуулалт	15
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛЫГ СУДАЛСАН ҮР ДҮН	20
2.1 Түүврийн бүтэц	20
2.2 Гэр бүл, мэргэжил сонголттой холбоотой асуудлыг судалсан үр дүн	22
Дэд бүлгийн дүгнэлт	28
2.3 Сургалтын төлбөр болон бусад зардалтай холбоотой асуудлыг судалсан үр дүн	28
Дэд бүлгийн дүгнэлт	37
2.4 Сургалт, мэдээллийн тэгш хүртээмжийг судалсан үр дүн	38
Дэд бүлгийн дүгнэлт	42
ДҮГНЭЛТ, САНАЛ	44

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУИС	Монгол Улсын Их Сургууль
АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
ДХИС	Дотоод Хэргийн Их Сургууль
ШУТИС	Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
ҮБХИС	Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгаанд оролцогчдын суралцаж буй сургууль /хувиар/	20
Зураг 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг /хувиар/	20
Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/	20
Зураг 4. Судалгаанд оролцогчдын суралцаж буй түвшин /хувиар/	21
Зураг 5. Судалгаанд оролцогчдын суралцаж буй мэргэжлийн чиглэлүүд /хувиар/	21
Зураг 6. Судалгаанд оролцогчдын бүртгэлтэй хаяг /хувиар/	21
Зураг 7. Судалгаанд оролцогчдын амьдарч буй газар /хувиар/	21
Зураг 8. Эцгийн боловсролын түвшин /хувиар/	22
Зураг 9. Эхийн боловсролын түвшин /хувиар/	22
Зураг 10. Эцгийн эрхэлж буй мэргэжийн салбар, чиглэл /хувиар/	22
Зураг 11. Эхийн эрхэлж буй мэргэжийн салбар, чиглэл /хувиар/	23
Зураг 12. Эцгийн боловсролын түвшин ба хүүхдийн голч дүн /хувиар/	23
Зураг 13. Эхийн боловсролын түвшин ба хүүхдийн голч дүн /хувиар/	24
Зураг 14. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн боловсролын түвшин /хувиар/	24
Зураг 15. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэргэжлийн салбар, чиглэл /хувиар/	24
Зураг 16. Судалгаанд оролцогчдын голч дүнгийн харьцаа /хувиар/	26
Зураг 17 Их, дээд сургуульд сурдаг гэр бүлийн гишүүд /хувиар/	26

Зураг 18. Мэргэжил сонголтод хэн нөлөөлсөн талаар /хувиар/	27
Зураг 19. Өрхийн орлого /хувиар/	28
Зураг 20. Өрхийн орлого ба амьдарч байгаа газар /хувиар/	28
Зураг 21. Сургалтын төлбөрийн асуудлаас үүдэн сургууль завсардсан эсэх /хувиар/ ...	30
Зураг 22. Сургалтын төлбөрөө төлдөг хэлбэр /хувиар/	31
Зураг 23. Сургалтын төлбөртэй холбоотой хүндрэл /хувиар/	31
Зураг 24. Сургалтын төлбөрөө төлдөг хэлбэр ба төлөхөд хэцүү байдал /хувиар/	31
Зураг 25. Ажил хийдэг эсэхийг сургуулиар нь харьцуулбал /хувиар/	32
Зураг 26. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн цаг /хувиар/	33
Зураг 27. Голч дүн ба ажил хийдэг цаг /хувиар/	33
Зураг 28. Голч дүн ба ажил хийдэг эсэх	33
Зураг 29. Сургалтын төлбөрөөс гадуурх зардал хүндрэлтэй байдал	34
Зураг 30. Цаашид суралцахад хүндрэлтэй асуудлууд байх эсэх /хувиар/	35
Зураг 31. Цаашид суралцахад хүндрэлтэй байгаа шалтгаан	35
Зураг 32. Гадуурхалтад өртөж байсан эсэх	38
Зураг 33. Нийгмийн гарал суралцах үйл явцад нөлөөлдөг эсэх /хувиар/	38
Зураг 34. Хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтэнтэй эсэх /хувиар/ ...	39
Зураг 35. Багш хөгжлийн бэрхшээлтэй оюутанд тохирсон арга барил ашигладаг эсэх /хувиар/	39
Зураг 36. Тэтгэлгийн мэдээллийн хүртээмжтэй байдал /хувиар/	40
Зураг 37. Оюутны холбоо, клубээс зохион байгуулдаг үйл ажиллагааны хүртээмжтэй байдал /хувиар/	40
Зураг 38. Тэтгэлгийн шалгуур тэгш хүртээмжтэй байдаг эсэх /хувиар/	41
Зураг 39. Оюутны холбоо, клубээс зохион байгуулдаг үйл ажиллагааны хүртээмж ба сургууль /хувиар/	41
Зураг 40. Тэтгэлгийн мэдээллийн хүртээмж ба сургууль /хувиар/	41
Зураг 41. Тэтгэлгийн шалгуур тэгш хүртээмж ба сургууль /хувиар/	41
Зураг 42. Их сургуулиудын орон нутаг дахь элсэлтийн тоо	42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн харьцуулалт	16
Хүснэгт 2. Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын тухай тусгасан	17
Хүснэгт 3. Голч дүн болон эцэг, эх, асран хамгаалагчийн боловсролын түвшин хоорондын хамаарлын шинжилгээний үр дүн	25
Хүснэгт 4. Оюутны голч дүн ба сургуулиудын хоорондын ялгаа	26
Хүснэгт 5. Мэргэжил сонголт ба эцгийн боловсролын түвшин	27
Хүснэгт 6. Эцгийн ажилладаг салбар ба сургалтын төлбөр төлдөг хэлбэрүүд	29
Хүснэгт 7. Эхийн ажилладаг салбар ба сургалтын төлбөр төлдөг хэлбэрүүд	29
Хүснэгт 8. Өрхийн орлого ба их, дээд сургуульд сурсан гэр бүлийн гишүүдийн тоо ...	30
Хүснэгт 9. Сургууль ба төлбөр төлөх хэлбэр	32
Хүснэгт 10. Өрхийн орлого ба төлбөр төлөлтийн хэлбэр	34
Хүснэгт 11. Сургалтын төлбөр төлөх хүндрэл ба нийгмийн гарал	34
Хүснэгт 12. Нэмэлт зардал ба амьдарч буй газар	35
Хүснэгт 13. Суралцахад гарч байгаа хүндрэл, бэрхшээлүүд	35
Хүснэгт 14. Цахим хичээлд хамрагдах нөөц, бололцоог ажил хийдэг эсэх болон нэмэлт зардалтай харьцуулсан байдал	36
Хүснэгт 15. Ялгаварлан гадуурхагдаж байгаа хэлбэр /хувиар/	38
Хүснэгт 16. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан хариуцсан мэргэжилтэн байдаг эсэх	39
Хүснэгт 17. Ялгаварлан гадуурхагдаж байсан шалтгаанууд ба сургууль /хувиар/	40
Хүснэгт 18. Ялгаварлан гадуурхал суралцах үйл явцад нөлөөлдөг эсэх /хувиар/	40
Хүснэгт 19. Ялгаварлан гадуурхал ба хүйс /хувиар/	40
Хүснэгт 20. Орон нутаг дахь элсэлтийн хяналтын тооны хүртээмж ба сургууль	42

УДИРТГАЛ

Үндэслэл

2015 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын ("НҮБ")-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилгыг 17 зорилго, 169 зорилттойгоор баталсан. Тогтвортой хөгжлийн зорилгын 4-т "чанартай боловсролыг дэмжих"-ээр тогтоосон.¹ Энэхүү зорилгын хүрээнд хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих зорилт тавьсан. Тогтвортой хөгжлийн зорилгын 4 дэх зорилгын 4.3 дахь зорилтын дагуу "бүх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд боломжийн, чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол, тэр дундаа их дээд сургуулиудад тэгш хүртээмжтэй байх боломжийг хангах"-аар заасан.² ЮНЕСКО-н судалгаагаар дээд боловсрол эзэмшихэд зориулсан нэг жил нь ирээдүйд авах цалин хөлсийг 10 хувиар нэмэх суурь болдог гэдгийг тогтоожээ.³ Их сургууль, дээд боловсролын хөтөлбөрт хамрагдах нь хувь хүний амьдралын чанарт өндөр ач холбогдолтой тул дээд боловсролын хүртээмжийг шударгаар тодорхойлох шаардлагатай.⁴ Дээд боловсрол эзэмших адил тэгш боломж бүрдүүлэх нь чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх нэг гол багана юм. Монгол улс хөгжлийн бодлогын баримт бичиг болон холбогдох хууль тогтоомжоор чанартай боловсрол эзэмших тэгш хүртээмжийг бүрдүүлэх талаар заасан. Гэвч дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдал практикт бодитоор хэрэгжиж байгаа эсэхийг судалж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох шаардлага үүсэж байна.

Энэхүү судалгаагаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит их, дээд сургуулиуд дахь дээд боловсролын тэгш хүртээмжийн нөхцөл байдлыг судлахын тулд Монгол Улсын Их Сургууль ("МУИС"), Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль ("АШУҮИС"), Санхүү эдийн засгийн их сургууль ("СЭЗИС"), Дотоод хэргийн их сургууль ("ДХИС"), Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль ("ШУТИС"), Хөдөө аж ахуйн их сургууль ("ХААИС"), Үндэсний батлан хамгаалахын их сургууль ("ҮБХИС"), Орон нутгийн их сургуульд суралцаж буй нийт 512 оюутнаас 2 бүлэг 34 асуултаас (нээлттэй 3, олон сонголттой 1, хаалттай 30) бүрдсэн асуулгыг авч, судалгааны үр дүнг гаргасан болно.

1 UN DESA, Sustainable Development Goals, Goal 4. <https://sdgs.un.org/goals/goal4> last accessed 7 June 2023.

2 Ibid.

3 UNESCO (2016) Global Education Monitoring Report, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245752> last accessed 7 June 2023.

4 Stanford University, Equality of Opportunity and Education. <https://edeq.stanford.edu/sections/section-3-equality-opportunity-and-education/higher-education> last accessed 7 June 2023.

Сэдвийн судлагдсан байдал

Боловсролын түвшнийг үл харгалзан авч үзвэл боловсролын тэгш хүртээмжтэй байдлын талаар 2020 онд Азийн Хөгжлийн банкны Зүүн Азийн Газраас эрхлэн гаргадаг Техникийн Цуврал Тайланд “Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь”⁵ судалгаа хийгдсэн байна. Тус судалгааны бүтээлд хөгжлийн бэрхшээл ба боловсролын хүртээмжийг судалж, тэгш хамруулах боловсролын индикаторууд болох тэгш хамруулах соёл, тэгш хамруулах бодлого, тэгш хамруулах практик үйл ажиллагаа, тэгш хамруулсан материаллаг орчныг боловсруулсан. Мөн 2019 онд ЮНЕСКО-оос эрхлэн гаргасан “Монгол улсын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь”⁶ судалгаагаар тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлэх, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох талаар судалсан. Тус бүтээлд багшлах боловсон хүчний бодлого, боловсролын бүх түвшин дэх суралцахуйн олон төрлийн боломжууд, мэдээлэл, харилцаа холбооны технологийг боловсролд өргөнөөр нэвтрүүлэх, малчин өрхийн хүүхдийн боловсролын асуудал, бүх нийтийн насан туршийн боловсролын асуудлуудыг хөндсөн байна. Дээрх хоёр судалгааны бүтээлд дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдлын талаар нарийвчлан судлаагүй байна. Иймд дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын талаар тухайлан судалсан нь энэхүү судалгааны ажлын шинэлэг тал болно.

Зорилго, зорилт

Энэхүү судалгаагаар дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын талаарх Монгол улсын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийг судлан, тэдгээрт тусгагдсан зорилго, зорилт, зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, судалгааны үр дүнд тодорхой санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Дээр дурдсан зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Монгол улсын бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомжид дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдлын талаар хэрхэн зохицуулсныг судална.
2. Монгол улсын төрийн өмчийн их, дээд сургуулиудын оюутнуудаас асуулгын аргаар судалгаа авч, түүнийг боловсруулна.
3. Монгол улсын дээд боловсролын тэгш хүртээмжийн нөхцөл байдалд тулгамдаж буй асуудлыг илрүүлнэ.
4. Эцэг эхийн боловсролын түвшин хүүхдийн боловсролын ирээдүйд нөлөөлдөг эсэхийг судлах.

Судалгааны шинэлэг байдал

Энэхүү судалгаа нь дээд боловсрол эзэмшихээр бакалаврын хөтөлбөрт суралцаж буй оюутнуудаас доорх 5 асуудлын хүрээнд дээд боловсролыг оюутан бүрт тэгш, хүртээмжтэйгээр эзэмшдэг эсэхийг тандан судлах, эдгээр асуудлууд нь оюутнуудыг сурч боловсроход нь хэрхэн нөлөөлж буй талаар тухайлан судлан, тоон болон чанарын судалгааны аргыг

5 Карин Шелциг, Кирсти Ньюман (2020) Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь, АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн цуврал тайлан Дугаар 28. <https://www.adb.org/mn/publications/promoting-inclusive-education-mongolia> -аас хамгийн сүүлд 2023.06.07-нд хандав.

6 ЮНЕСКО (2019) Монгол улсын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687_mon -аас хамгийн сүүлд 2023.06.07-нд хандав.

ашиглан үр дүнг боловсруулсан нь судалгааны шинэлэг тал болно.

1. Улаанбаатар хот болон орон нутаг дахь их, дээд сургуулиуд хүртээмжтэй эсэх;
2. Дээд боловсрол эзэмших бакалаврын хөтөлбөрт суралцаж буй оюутнуудын жендэрийн тэгш байдал хангагдаж байгаа эсэх;
3. Нийгмийн гарал үүсэл, хөрөнгө, орлогын байдал, эцэг эх, асран хамгаалагч нарын боловсролын түвшин зэрэг нь дээд боловсрол эзэмшихэд нь хамаарч байгаа эсэх;
4. Их сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан тусгай мэргэжилтэн, тоног төхөөрөмжийн хүртээмжтэй байгаа эсэх;
5. Цахимаар хичээллэхэд оюутнуудад шаардлагатай тоног төхөөрөмжүүд хүртээмжтэй байгаа эсэх гэсэн таван асуудлын хүрээнд тус тус судлан, судалгаа хийсэн болно.

Судалгааны хүрээ

Энэхүү судалгаа нь дараах хүрээнд явагдсан.Үүнд:

1. Судалгааны онолын хэсэгт дээд боловсролын тэгш хүртээмжийн талаарх холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийг тус тус судалсан.
2. Судалгааны асуумжтай холбогдуулан Улаанбаатар хот болон орон нутаг дахь их дээд сургуульд элсэх квотын хүртээмжтэй байдал, дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй оюутнуудын жендэрийн тэгш харьцаа, дээд боловсрол эзэмшихэд нийгмийн гарал үүсэл, хөрөнгө, орлого, мөн тухайн оюутны эцэг, эх, асран хамгаалагч нарын боловсролын түвшний хамаарал, их дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан тусгай мэргэжилтэн, тохируулга, хүртээмжтэй байдал, цахимаар хичээллэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн хүртээмжтэй байдал зэргийг тус тус судалсан.
3. Судалгааны үр дүнг танилцуулах хэсэгт МУИС, АШУҮИС, ДХИС, ШУТИС, ХААИС, МУБИС, СЭЗИС, ҮБХҮИС зэрэг сургуулиудын 1-6 дугаар түвшний 512 оюутнуудаас судалгааг авч, судалгааны үр дүнг боловсруулсан.
4. Судалгааны төгсгөлийн хэсэгт үр дүнг нэгтгэн дүгнэсэн.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргуудыг хослуулан ашигласан. Түүврийн хэмжээг Монгол Улсын хэмжээнд дээд боловсрол олгож буй 7 их сургуулийн 1-6 дугаар түвшний санамсаргүй түүврийн аргаар сонгосон нийт 512 оюутнаар тогтоосон. Судалгааг асуулгын аргыг ашиглан авсан ба асуулга нь 2 бүлэг, нээлттэй 3 асуулт, 1 олон сонголттой асуулт, 30 хаалттай асуулт нийт 34 асуултаас бүрдэж байгаа бөгөөд боловсруулсан асуулгыг судалгааны багийн гишүүд 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 4-ний өдрийг хүртэл цахимаар авсан. Судалгааны үр дүнг SPSS программ ашиглаж дүгнэсэн.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААРХ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу иргэн бүр сурч боловсрох эрхтэй⁷ бөгөөд хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй.⁸ Сурч боловсрох эрх нь хүний суурь эрх бөгөөд хувь хүний бүтээмж, сайн сайхан байдал болоод улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал хүчин зүйл болдог.⁹ Тийм ч учраас хүний эрхийн олон улсын гэрээнд боловсролын тэгш хүртээмжийн талаар зохицуулсан. 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр сурч боловсрох эрхтэй. ... техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол нийтэд хүртээлтэй байх ёстой”¹⁰ гэж заасан. Харин 1976 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13(2)(с)-д “...дээд боловсролыг бүгдэд ижил хүртээмжтэй болгох”¹¹ хэрэгтэй гэдгийг тогтоосон. Дээд боловсрол тэгш, хүртээмжтэй байх нь сурч боловсрох эрхийн нэг хэсэг болдог байна. Боловсролын тэгш хүртээмжтэй байдлын талаар судлахын өмнө онолын хувьд зүй ёс, тэгш боломжийн талаар авч үзэх шаардлагатай.

Жон Роулс 1971 онд бичигдсэн “Зүй ёсны онол” (A Theory of Justice) бүтээлдээ тэгш бус боломжийн талаар цогцоор нь тодорхойлсон. Жон Роулс “зүй ёс бол шударга ёс” гэж үзсэн бөгөөд “үл мэдэхүйн хөшиг” гэх сэтгэхүйн туршилтаар дамжуулан тус ойлголтыг тайлбарладаг. Зүй ёсны ямар зарчим шударга вэ гэвэл өөрсдөө хэрхэн өнөөгийнхөө байранд ирснийг үл мэдэх хүмүүсийн сонгосон зарчим шударга гэж үздэг.¹² Хүмүүс хуваасан бялууныхаа ямар хэсгийг өөрт оногдохыг мэдээгүй тохиолдолд мэдэж байснаасаа илүү тэнцүү хуваахыг хичээх болно. Хэрэв тэд өөрсдийнхөө бусдаас ялгаж буй ялгааг мэдэх аваас түүндээ тохирсон сонголт хийх хандлагатай байдаг.¹³

7 Монгол Улсын Үндсэн хууль (1992) 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/367> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

8 Монгол Улсын Үндсэн хууль (1992) 14 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/367> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

9 UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education, p.11. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

10 ХЭҮК, Хүний эрхийн олон улсын билл: Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл, УБ., 2019 он. 19 дэх тал.

11 ХЭҮК, Хүний эрхийн олон улсын билл: Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл, УБ., 2019 он. 95 дах тал.

12 Адам Свифт, Улс төрийн философи, Эрх зүйт ёс сан, УБ., 2014 он. 37 дахь тал.

13 Мөн тэнд.

1.1 Нийгмийн гарал үүсэл, хөрөнгө чинээ

Эхэндээ нийгмийн бүлгээс гаралтай хүмүүс их сургуульд элсэн орох боломжтой байсан бол 20-р зуунд “тэгш боломж”, “боломжийн тэгш байдал” (equality of opportunity)-ын тухай ойлголт үүссэн.¹⁴ Дээд боловсролын тэгш хүртээмжийн хүрээнд боломжийн тэгш байдал (equality of opportunity)-ын асуудал зайлшгүй хөндөгддөг. Боломжийн тэгш байдал нь төрсөн нөхцөл байдлаас үл хамааран хүн бүр адил хөгжих боломжтой байх ёстой гэдгийг илэрхийлдэг.¹⁵ Жон Роулсын зүй ёсны онолын дагуу үл мэдэхүйн хөшигний цаана байгаа талууд дараах хоёр зүйлийг үл мэднэ гэж хийсвэрлэн тооцдог. Нэгд, талууд өөрсдийн авьяас, байгалиас заяасан чадвар, нийгмийн байр суурийг мэдэхгүй. Мөн өөрсдийн арьс өнгө, баян ядуу, ямар айлд төрснийг эс мэднэ. Хоёрт, сайн сайхны талаарх өөрсдийн ухагдахууныг ч мэдэхгүй. Мөн амьдралыг юу үнэ цэнтэй болгодог, шашин шүтдэг, эс шүтдэгээ эс мэднэ.¹⁶ Эдгээр нь хүмүүс зүй ёсны талаар хэрхэн сэтгэх ёстой вэ гэдгийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, аливаа улс боловсролын тогтолцоогоо авьяас, байгалиас заяасан чадвар, нийгмийн байр суурь, хөрөнгө чинээ, шашин шүтлэг зэргээс үл шалтгаалан хараат бусаар боловсруулах хэрэгтэй. Ингэснээр зүй ёс буюу шударга ёсыг хангаж, тэгш боломжийг бий болгоно гэж үздэг байна.

Боловсролын салбар дахь тэгш боломжийг хөрөнгө чинээ, жендэр, байршил зэрэг амьдралын нөхцөл байдалтай холбоотойгоор авч үздэг.¹⁷ Тэр дундаа нийгэм эдийн засгийн үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээгээр оюутны гэр бүлийн гарал үүсэл их сургуульд элсэн ороход хүчтэй нөлөө үзүүлдгийг тогтоожээ. Тухайлбал, өндөр боловсролтой эцэг, эхтэй бол их сургуульд элсэн орох магадлал өсдөг байна.¹⁸ Их, дээд сургуулийн зүгээс эдийн засгийн түвшин доогуур оюутанд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр оюутан сургуулиа орхихгүй байх, үргэлжлүүлэн суралцахад эерэг нөлөөлөл үзүүлдэг байна.¹⁹ Учир нь эдийн засгийн түвшин доогуур гэр бүлтэй оюутан үргэлжлүүлэн суралцах магадлал бага байдаг.²⁰

1.2 Цахим хичээлийн хүртээмжтэй байдал

Коронавируст цар тахлын үед дээд боловсролын байгууллагууд технологийн шийдлийг ашиглан онлайнаар хичээллэх шаардлагатай болсон. Үүнийг дагаад тэгш боломжийн асуудал хөндөгдсөн.²¹ Технологийн тоног төхөөрөмжийн хүртээмжгүй байдал дижитал тэгш боломж (digital equity)-ын асуудлыг үүсгэдэг. 2019 онд Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний Дижитал Оролцооны Холбоо (National Digital Inclusion Alliance) дижитал тэгш боломжийг “Бүх хүн болоод бүлэг өөрийн нийгэм, ардчилал, эдийн засагт бүрэн дүүрэн оролцоход шаардагдах мэдээллийн технологийн чадвартай байх нөхцөлийг ойлгоно. Дижитал тэгш байдал нь нийгэм, соёлын оролцоо, хөдөлмөр эрхлэлт, насан туршийн

14 Tristan McCowan, Three Dimensions of Equity of Access to Higher Education, Compare (2016), 46 (4), p.6. https://www.researchgate.net/publication/281221321_Three_dimensions_of_equity_of_access_to_higher_education last accessed 13 June 2023.

15 UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education, p.11. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

16 Адам Свифт, Улс төрийн философи, Эрх зүйт ёс сан, Уб., 2014 он. 38 дахь тал.

17 UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education, p.30. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf> last accessed 13 June 2023.

18 Mega Wanti, Renate Wesselink, Harm Biemans and Perry den Brok (2022) Determining factors of access and equity in higher education: A systematic review, Equity in Education & Society Vol. 1(2) 279–296, p.288. <https://journals.sage-pub.com/doi/pdf/10.1177/27526461221092429> last accessed 14 June 2023. (“Mega Wanti”)

19 Mega Wanti, p.286.

20 Mega Wanti, p.288.

21 UNESCO (2020) Quality Assurance and Recognition of Distance Higher Education and TVET, COVID-19 Education Response Education Sector issue notes, p.1. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373754> last accessed 15 June 2023.

суралцахуй болон бусад нэн чухал үйлчилгээнд хамрагдахад шаардлагатай”²² гэж тодорхойлсон. Дижитал тэгш боломж нь i) боловсролын давуу тал; ii) ирээдүйн хөдөлмөр эрхлэлт ба орлого, iii) нийгэм ба иргэний оролцоо; iv) тэгш боломж ба иргэний эрх гэсэн үндсэн дөрвөн шалтгаан буюу үндэслэлээр анхаарлын төвд ороод байна.²³ Юун түрүүнд интернэтэд холбогдох боломжтой байх нь дээд боловсрол эзэмшиж буй оюутнуудын дижитал тэгш боломжид чухал нөлөөтэй.²⁴

Коронавируст цар тахлын үед оюутнууд гэрээсээ суралцахын тулд компьютер, хурдтай интернэт шаардлагатай болсон боловч эдгээр хэрэгсэл оюутан бүрд харилцан адилгүй байх тул тэгш бус байдлыг үүсгэсэн.²⁵ Тэр дундаа хөдөө, орон нутагт амьдарч буй оюутнууд дижитал боловсрол эзэмшихэд бэрхшээлтэй байгаа юм.²⁶ Иймд зарим тохиолдолд засгийн газар болон их сургууль бага орлоготой оюутнуудад компьютер үнэ төлбөргүй тараах арга хэмжээ авчээ. Тухайлбал, Франц улсын Страсбургийн Их Сургууль 100 (нэг зуун) ширхэг компьютерыг хэрэгцээтэй байгаа оюутнуудад тараасан бол Ирланд улс бага орлоготой оюутнуудад мэдээллийн технологийн тоног төхөөрөмж тараахын тулд 15 (арван тав) сая евро зарцуулжээ.²⁷ Тиймээс цахим сургалтын үед технологийн тоног төхөөрөмжийн хүртээмжгүй байдал дээд боловсролын тэгш боломжид шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

1.3 Орон нутаг дахь их, дээд сургуулийн хүртээмжтэй байдал

Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд 69 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 33 буюу 47.8 хувь нь их сургууль, 35 буюу 50.7 хувь нь дээд сургууль, 1 буюу 1.4 хувь нь коллеж байна. Нийт их, дээд сургууль, коллежийн 16 буюу 23.2 хувь нь төрийн өмчийн, 50 буюу 75.5 хувь нь хувийн өмчийн, 3 буюу 4.3 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна. Нийт сургалтын байгууллагын 64 буюу 92.8 хувь нь Улаанбаатар хотод, 5 буюу ердөө 7.2 хувь нь хөдөө, орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулж байна.²⁸ Хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн тоо, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн тооноос илт цөөн байгаа юм.

Сүүлийн 5 жилийн хугацаанд орон нутгийн их, дээд сургуульд суралцагчдын тоо жил ирэх тусам буурч байна.²⁹ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулиудад сүүлийн 10 орчим жилд элсэлтийн тоо буурснаар санхүүгийн байдал хүндрэх болжээ.³⁰ Энэхүү судалгаанаас үзвэл орон нутаг дахь их, дээд сургуулийн тоо хүртээмжтэй бус байгаагаас үүдэн сурагчид Улаанбаатар дахь их, дээд сургуульд элсэн орж байна гэж дүгнэх үндэслэлгүй байна. Харин эсрэгээрээ элсэгчид орон нутаг дахь их, дээд сургуулийг сонгон

22 Julie A. Willems, Chris Campbell, Helen Sara Farley (2019) The Increasing Significance of Digital Equity in Higher Education: An Introduction to the Digital Equity Special Issue, Australasian Journal of Educational Technology 35(6), p.1. https://www.researchgate.net/publication/338263351_The_increasing_significance_of_digital_equity_in_higher_education_An_introduction_to_the_Digital_Equity_Special_Issue last accessed 16 June 2023. ("Julie A. Willems")

23 Julie A. Willems, p.3.

24 Julie A. Willems, p.2.

25 Right to Education, Covid-19 and technical difficulties: the rise of inequalities in higher education. <https://www.right-to-education.org/blog/covid-19-and-technical-difficulties-rise-inequalities-higher-education> last accessed 16 June 2023.

26 Ibid.

27 Ibid.

28 Дээд боловсролын 2022-2023 оны статистик. https://www.meds.gov.mn/posts?category_id=11403 –аас хамгийн сүүлд 2023.06.14-нд хандав.

29 Баяржаргалын Цог, Орон нутгийн их, дээд сургуулиудын элсэлтийн байдал, бодлогын зорилт, хэрэгжилт, УБ., 2020 он. 1 дэх тал. <https://higher-education-new-era-journal.mn/assets/front/images/pdf/articles/914b3z7Aac1VQmSMrBp-MdSFRIcS1QMUAk6cGc6JH.pdf> –аас хамгийн сүүлд 2023.06.15-нд хандав. ("Баяржаргалын Цог").

30 Баяржаргалын Цог, 2 дахь тал.

суралцахгүй байгаа тул тэдгээр сургуулиуд санхүүгийн хүндрэлд орох болжээ. Иймд хүн амын төвлөрлөөс шалтгаалан орон нутаг дахь их, дээд сургуульд элсэн суралцагчдын тоо буурч буй тул орон нутаг дахь их, дээд сургуулийг хүртээмжгүй байна гэж дүгнэх боломжгүй байна.

1.4 Жендэрийн тэгш байдал

1948 онд батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд “Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Авьяас чадвартай нь уялдан хүн бүрд дээд боловсрол эзэмших боломж адилхан хүртээлтэй олгох ёстой”³¹ хэмээн заасан байдаг. 2011 оны 2 дугаар сарын 2 –ны өдөр батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна”³² гэсэн нь эрэгтэй, эмэгтэй хүн бүр аль ч шатны боловсрол эзэмших эрхтэй талаар тухайлан хуульчилсан байна. Монгол Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид нийт 145,267 суралцагч (56,444 буюу 38.9 хувь нь эрэгтэй, 88,823 буюу 61.1 хувь нь эмэгтэй) суралцаж байна. Шинээр 26,316 суралцагч (9,767 буюу 37.1 хувь нь эрэгтэй, 16,549 буюу 62.9 хувь нь эмэгтэй) элссэн байна.³³ Мөн 2019 онд ЮНЕСКО-с хийгдсэн Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээнд дурдсанаар 2008-2019 оны хооронд дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэй иргэдийн тоо эрэгтэй иргэдээс дунджаар 22 хувиар илүү үзүүлэлттэй гарчээ. Монгол улсын дээд боловсролын салбарын оролцооны түвшний хувьд 2018 оны байдлаар нийт эмэгтэйчүүдийн 23%, эрэгтэйчүүдийн 17% нь бакалавр эсвэл магистрын зэрэгтэй байна.³⁴

Боловсролын бүх түвшинд эрэгтэй сурагчдын сурлагын амжилт, сургууль дүүргэлтийн түвшин эмэгтэй сурагчдынхаас доогуур байдаг ба их сургуульд элсэн суралцах хувь нь ч доогуур байдаг байна. Охид, залуу эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөвгүүд, залуу эрчүүдэд ахлах болон дээд боловсролд хамрагдахад, сургуулиа амжилттай дүүргэж, төгсөхөд илүү хэцүү байдаг нь эрэгтэй сурагчдыг ялгаварлан гадуурхдаг сургалтын байгууллагын практик болон тэдэнд учирдаг саад бэрхшээлийг амжилттай шийдэж чадаагүйг илэрхийлж байна.³⁵

Үүнээс харахад боловсролын салбарт, тэрдундаа дээд боловсролын салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь жендэрийн харьцаа тэнцвэргүй байгааг илтгэж байна.

1.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын боловсролын тэгш хүртээмж

Монгол Улсад олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр тэгш хамруулах зарчмаар боловсролд хамруулах үзэл санаа 2003 оноос хойш илүү эрчимжсэн бөгөөд 2016 онд Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгагджээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах үзэл баримтлалаар боловсролд хамруулах үйл ажиллагааг

31 Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948) 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1271> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

32 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/253> аас хамгийн сүүлд 2023.06.15-нд хандав

33 Дээд боловсролын 2022-2023 оны статистик. https://www.meds.gov.mn/posts?category_id=11403 -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

34 UNESCO Education Policy Review: Towards a Lifelong Learning System (June 2020), p.47. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687/PDF/373687eng.pdf.multi> last accessed 13 June 2023.

35 UNESCO Education Policy Review: Towards a Lifelong Learning System (June 2020), p.152. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687/PDF/373687eng.pdf.multi> last accessed 13 June 2023.

сайжруулах талаар 2005 оны Боловсролын салбарын тойм шинжилгээ, Мастер төлөвлөгөө (2006-2015) болон Боловсролын салбарын гурав дахь (2006-2011) бичиг баримтуудад тусгалаа олж байжээ.³⁶

Боловсролын тухай хуулийн 42.1 дүгээр зүйлд “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”.³⁷ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3 дугаар зүйлд “бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх”, мөн хуулийн 16.2 дугаар зүйлд “бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна”³⁸ хэмээн тус тус заасан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, “Боловсролын тухай хууль”-д тухайлан тусгаж өгсөн байгаа нь сайшаалтай боловч Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад тэдний хэрэгцээнд таарсан хүртээмжтэй орчин бүрдээгүй хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан тусгай мэргэжилтэн, тоног төхөөрөмжийн хүртээмжийн талаарх судалгааг судалгааны хэсгээс харах боломжтой.

1.5 Эрх зүйн зохицуулалт

Судалгааны энэ хэсэгт дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын талаарх i) Монгол Улсын бодлогын баримт бичиг дэх зорилго, зорилт болон ii) холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг авч үзэх болно.

1.5.1 Бодлогын баримт бичиг

Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын тухай тусгасан дараах бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байна.

“Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого;

“Гурван тулгуурт хөгжлийн бодлого”; болон

“Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлал”.

2016 оны 02-р сарын 05-ны өдөр Монгол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийн Зорилт 4-т “Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно”³⁹ гэж заасан. Энэ хүрээнд I үе шат буюу 2016-2020 онд “сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн загварт түшиглэсэн, олон

36 UNESCO Education Policy Review: Towards a Lifelong Learning System (June 2020), p.47. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687/PDF/373687eng.pdf.multi> last accessed 13 June 2023.

37 Боловсролын тухай хууль (2002) 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/9020>-аас хамгийн сүүлд 2023.06.14-нд хандав.

38 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016) 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/11711>-аас хамгийн сүүлд 2023.06.14-нд хандав.

39 Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02-р сарын 05-ны өдрийн Дугаар 19 Тогтоол, Хавсралт 1 “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207105&showType=1> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай дээд боловсролын үйлчилгээ үзүүлэх⁴⁰ зорилт тавьсан. Харин II үе шат буюу 2021-2025 онд “хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу шинжлэх ухаан, технологийн кластер, парк байгуулж, үндэсний дөрвөөс доошгүй их сургууль Азийн шилдэг их сургуулийн эгнээнд орсон байх”⁴¹ зорилтыг дэвшүүлсэн. III үе шат буюу 2026-2030 онд “олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байх”⁴² зорилтыг тус тус тавьжээ. Гэвч 2020 онд “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталснаар “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ийг хүчингүй болсонд тооцсон тул дээрх зорилтуудыг хэрэгжүүлэлгүй үлдээсэн байна.

“Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм зорилгод (Цаашид “Алсын хараа - 2050” гэх) эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжих⁴³ зорилгыг тавьсан. Тус эрхэм зорилгын хүрээнд Алсын хараа 2050-ийн Зорилт 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ”⁴⁴ гэж заасан. 1-р үе шат буюу 2021-2030 оныг “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе” гэж нэрлэж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэхээр заасан. 2-р үе шат буюу 2031-2040 онд “олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болох” зорилт дэвшүүлсэн.⁴⁵ Үүнээс үзвэл боловсролын түвшингээс үл хамааран бүх түвшний хувьд хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх зорилтыг тавьжээ. Харин дээд боловсролын тухайд дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлээд байна. Өмнөх Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-тай харьцуулахад тэгш, хүртээмжтэй дээд боловсролын үйлчилгээ үзүүлэхээр тухайлан заагаагүй байна.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичгийн харьцуулалт

№	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030	“Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
1.	Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

40 Мөн тэнд.

41 Мөн тэнд.

42 Мөн тэнд.

43 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05-р сарын 13-ны өдрийн Дугаар 52 Тогтоол, Хавсралт 1 “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хөгжлийн бодлого. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1> -аас хамгийн сүүлд 2023.06.07-нд хандав.

44 Мөн тэнд.

45 Мөн тэнд.

2.	сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн загварт түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай дээд боловсролын үйлчилгээ үзүүлэх.	Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болох.
----	---	---

Харин Засгийн газрын баталсан “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-оор дээд боловсролын салбарт бодлогын шинэчлэл хийж, тоо хэмжээний бус чанарын шаардлагыг анхаарч, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр⁴⁶ зохицуулсан. Гэтэл энэ нь Улсын Их Хурлын баталсан Алсын хараа-2050-ийн олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилттой нийцэхгүй байна. Зөвхөн чанарын шаардлагыг анхаараад зогсохгүй, дээд боловсролын байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилт тавьсан байна.

Түүнчлэн Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлалаар хүн амын зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшнийг ойртуулах⁴⁷ зорилго тавьсан. Энэ хүрээнд тус үзэл баримтлалын 4.7.4-т зааснаар “бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжих”⁴⁸-ээр зохицуулжээ.

1.5.2 Хууль тогтоомж

Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын тухай тусгасан дараах хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хүснэгт 2. Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлын тухай тусгасан хууль тогтоомжийн жагсаалт

№	Хэлбэр	Нэр
1.	Хууль	Монгол Улсын Үндсэн хууль (1992) Боловсролын тухай хууль (2002) Дээд боловсролын тухай хууль (2002) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
2.	Дүрэм	Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм (2007)
3.	Монгол Улсын олон улсын гэрээ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1976)

Монгол Улсад хүн бүр боловсрол эзэмших эрхтэй тухай холбогдох хуулиудад хуульчилсан байдаг. Тухайлбал 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн

46 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02-р сарын 16-ны өдрийн Дугаар 42 Тогтоол “Гурван тулгуурт хөгжлийн бодлого батлах тухай” <https://legalinfo.mn/mn/detail/13240> -аас хамгийн сүүлд 2023.06.13-ны өдөр хандав.

47 Монгол Улсын Их Хурлын 2001 оны 06-р сарын 14-ний өдрийн Дугаар 57 Тогтоолын Хавсралт “Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал”, 2.1 дэх хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203158&showType=1> -аас хамгийн сүүлд 2023.06.15-ны өдөр хандав. (“Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал”)

48 Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал”, 4.7.4 дэх хэсэг.

хуулийн 16 дугаар зүйлд “сурч боловсрох эрхтэй”⁴⁹ тухай, 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт “Монгол Улсын иргэн бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу төлбөргүй буюу төлбөртэйгөөр сурч эзэмших, ажил эрхлэхийн зэрэгцээ суралцах эрхтэй”⁵⁰, мөн хуулийн 5.1.4 дүгээр хэсэгт “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана”, мөн хуулийн 42.1 дэх хэсэгт “боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна”⁵¹, мөн хуулийн 44.2.8 дахь хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх” зэргээр заасан байгаа нь хүйс, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал, хөрөнгө чинээ зэргээс үл хамааран хүн бүр тэгш, хүртээмжтэйгээр сурч боловсрох эрхтэй тухай нарийвчлан заасан байна.

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “их сургууль, дээд сургууль, коллежид бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг түүний мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ, сурах чадварыг харгалзан элсүүлэх бөгөөд элсэлт нь сонголт хийх боломжтой, шалгаруулалт нь нээлттэй, хүртээмжтэй, үнэлгээний зохистой арга хэлбэр бүхий байна”⁵² хэмээн хуульчлан тусгасан байгаа ч орон нутагт их дээд сургуулиудын шинээр оюутан элсүүлэх хэмжээ нь мэргэжлээс шалтгаалан цөөн квоттой байдаг, элсэлтийн ерөнхий шалгалтын (ЭЕШ) дүнгийн эрэмбээр сургуулиа сонгох нь тэгш хүртээмжгүй байх, суралцагчийн өөрийн хүссэн мэргэжлээ сонгох боломжгүйд хүрэх магадлалтай байна.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр сурч боловсрох эрхтэй тухай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах эрхтэй тухай, мөн бие махбодын аливаа төрлийн бэрхшээлээс нь үүдэн ялгаварлан гадуурхахгүй байх талаар хуульд тусгасан байна. Тухайлбал, тус хуулийн 6.3.3 дахь хэсэгт “хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандахыг хориглох тухай”⁵³, мөн хуулийн 14.1.3 дахь хэсэгт “бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх”⁵⁴ талаар эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдаг ч их,

49 Монгол Улсын Үндсэн хууль (1992) 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/367> -аас хамгийн сүүлд 2023.06.13-нд хандав.

50 Боловсролын тухай хууль (2002) 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/9020>-аас хамгийн сүүлд 2023.06.16-нд хандав.

51 Боловсролын тухай хууль (2002) 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/9020>-аас хамгийн сүүлд 2023.06.16-нд хандав.

52 Дээд боловсролын тухай хууль (2002) 7 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/251>-аас хамгийн сүүлд 2023.06.17-нд хандав.

53 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016) 6 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/11711> -аас хамгийн сүүлд 2023.06.16-нд хандав.

54 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016) 14 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/11711> -аас хамгийн сүүлд 2023.06.16-нд хандав.

дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй оюутны хэрэгцээг хангахуйц анги танхим дутмаг байгааг дурдах нь зүйтэй.

2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна”⁵⁵ хэмээн тусгасан нь хүйсээс үл хамааран хүн бүр боловсролыг тэгш, хүртээмжтэйгээр эзэмших тухай тусгасан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 401 дүгээр тушаал “Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийн 6.2.1 дэх хэсэгт “зохих шаардлагыг хангасан сургалт явуулах хичээлийн байр, дотуур байр, ширээ, сандал, үзүүлэн таниулах, номын сан, лаборатори, туршилтын үйлдвэр, сургалт, эрдэм шинжилгээний болон бусад хэрэгсэл, номын сан, интернэтийн сүлжээ, сургуулийн эрүүл мэндийн төв зэрэг суралцахад шаардлагатай нөхцөл бололцоогоор хангуулах, тэдгээрийг зохих журмын дагуу ашиглах эрхтэй”⁵⁶ хэмээн тусгасан байдаг ч хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын хувьд эдгээр нь тэгш, хүртээмжтэй байдаггүй нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь дээд боловсрол тэгш, хүртээмжтэй авч чадахгүйд нөлөөлж байна.

55 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг <https://legalinfo.mn/mn/detail/253>-аас хамгийн сүүлд 2023.06.16-нд хандав.


56 Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм 6 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг (2007) <https://legalinfo.mn/mn/detail?lawId=204919&showType=1>-аас хамгийн сүүлд 2023.06.17-нд хандав

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТЭГШ ХҮРТЭЭМЖ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ СУДАЛСАН ҮР ДҮН


2.1 Түүврийн бүтэц

Зураг 1. Судалгаанд оролцогчдын суралцаж буй сургууль /хувиар/




Судалгаанд нийт 7 төрийн өмчит сургуулийн 1-6 дугаар түвшний нийт 512 оюутныг судалгаандаа хамруулсан. Үүнээс 28.6 хувийг АШУУИС, 22.1 хувийг СЭЗИС, 20 хувийг ДХИС, 17 хувийг МУИС, 4.7 хувийг ШУТИС, 0.6 хувийг МУБИС, 0.4 хувийг ХААИС, 6.7 хувийг бусад их, дээд сургуулийн оюутнууд эзэлж байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг /хувиар/




Зураг 3. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа /хувиар/



Судалгаанд оролцогчдын 62.2 хувь нь эмэгтэй, 25.6 хувь нь эрэгтэй 0.8 хувь нь бусад хүйсийн хүмүүс байв. Эндээс харахад, дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэйчүүдийн хувь хэмжээ нь эрэгтэйчүүдээсээ их байна. Харин насны бүлгээр нь авч үзэхэд 72.1 хувийг 20-24 насныхан, 25.6 хувийг 15-19 насныхан эзэлж үлдсэн 2.3 хувийг 25-с дээш насны хүмүүс байлаа.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын суралцаж буй түвшин /хувиар/




Зураг 5. Судалгаанд оролцогчдын суралцаж буй мэргэжлийн чиглэлүүд /хувиар/




Судалгаанд 30.7 хувь нь 3-р түвшин, 21.7 хувь нь 2-р түвшин, 20.9 хувь нь 1-р түвшин, 20.2 хувь нь 4-р түвшний оюутнууд эзэлж байна. Судалгаанд оролцогчид 60 гаруй төрлийн мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа бөгөөд тэдгээр мэргэжлийг зорилго, чиглэлээс нь хамааран бүлэглэн ангилахад анагаах ухаан, эрүүлийг хамгаалах чиглэлд (25.5%), хууль эрх зүй (23.9), бизнес санхүү (15.7%), эдийн засаг (9.9), мэдээллийн технологи (7.7), олон улсын харилцаа (5.7%), инженер уул уурхай (3.3%), байгалийн шинжлэх ухаан (2.4%), төрийн удирдлага (2.2%), нийгэм олон нийт (2%), бусад мэргэжлийн чиглэлээр (1.2%) байна.

Зураг 6. Судалгаанд оролцогчдын бүртгэлтэй хаяг /хувиар/



Зураг 7. Судалгаанд оролцогчдын амьдарч буй газар /хувиар/




Судалгаанд оролцогчдын 38.9 хувь нь орон нутгаас, 61.1 хувь нь УБ хотоос суралцаж буй оюутнууд байлаа. Тэдний 33.3 хувь нь гэртээ амьдардаггүй ба үүнээс 12.3 хувь нь


хамаатныхаа гэрт, 10.1 хувь нь түрээсний байранд, 9 хувь нь оюутны байранд, 0.4 хувь нь найзынхаа гэрт амьдардаг байна.

2.2 Гэр бүл, мэргэжил сонголттой холбоотой асуудлыг судалсан үр дүн

Зураг 8. Эцгийн боловсролын түвшин /хувиар/



Зураг 9. Эхийн боловсролын түвшин /хувиар/



Эцгийн боловсрол: 43.5 хувийнх нь эцэг нь дээд боловсролтой; 30.4 хувийнх нь бүрэн дунд боловсролтой; 15.5 хувь нь техник, мэргэжлийн боловсролтой байсан ба 1.2 хувь нь боловсрол эзэмшээгүй байна.

Эхийн боловсрол: 61 хувь нь дээд боловсролтой; 21.7 хувь нь бүрэн дунд; 12 хувь нь техник мэргэжлийн; 3.2 хувь нь бүрэн бус дунд; 1.2 хувь нь мөн боловсрол эзэмшээгүй байна. Ээжүүдийн талаас илүү хувь нь дээд боловсролтой гэсэн үр дүн гарлаа.


Зураг 10. Эцгийн эрхэлж буй мэргэжлийн салбар, чиглэл /хувиар/



Эцгийн эрхэлж буй ажил мэргэжлийн хувьд (23.4%) нь инженерчлэл, үйлдвэрлэл, барилгын салбарт, (21%) нь бизнес, удирдлага, эрх зүй, (17.5%) нь үйлчилгээний салбар ба цэрэг батлан хамгаалах (13.4%) нь ХАА, ой загасны аж ахуй, мал эмнэлэг, (5.8%) нь нийгмийн шинжлэх ухаан, сэтгүүл зүй, боловсролын салбарт, (4.9%) нь бусад салбарт бол эрүүл мэнд (3.6%), уул уурхай (2.8%), мэдээлэл харилцаа, технологи (2.3%), байгалийн шинжлэх ухаан,


математик, статистик (1.5%), урлаг хүмүүнлэг (1.3%), төрийн байгууллага (0.6%), санхүү эдийн засгийн салбарт (0.4%) тус тус ажиллаж байгаа бол (0.8%) нь тэтгэвэрт гарсан байна.

Зураг 11. Эхийн эрхэлж буй мэргэжлийн салбар, чиглэл /хувиар/




Эхийн эрхэлж буй ажил мэргэжлийн хувьд боловсролын салбарт хамгийн өндөр буюу (20.9%), бизнес, удирдлага, эрх зүйн салбарт (20.6%), үйлчилгээ, спорт, батлан хамгаалах салбарт (15.9%), эрүүл мэнд нийгмийн хамгаалах салбарт (12.2%), ХАА, ой, мал эмнэлгийн салбарт, (10.7%), инженерчлэл, үйлдвэрлэл, барилгын салбарт (7.8%), мэдээлэл харилцаа холбоо технологийн салбарт (3.3%), банк санхүү (1.5%), байгалийн шинжлэх ухаан, статистик (1.2%), урлаг хүмүүнлэг, (1.2%), төрийн байгууллагад (0.4%) нь ажилладаг бол (1%) нь тэтгэвэрт, (0.4%) нь ажилгүй байгаа бол үлдсэн (0.6%) нь бусад салбарт ажиллаж байна.

Зураг 12. Эцгийн боловсролын түвшин ба хүүхдийн голч дүн /хувиар/



Эцгийн боловсролын түвшин хүүхдийн голч дүнгийн хооронд статистик шинжилгээ хийж үзэхэд хамаарал байхгүй гэж гарсан боловч голч дүн 2-оос доош байхад эцгийн боловсролын түвшин бүрэн бус дунд, бүрэн дунд боловсрол давамгайлал илэрч байна.

Зураг 13. Эхийн боловсролын түвшин ба хүүхдийн голч дүн /хувиар/



Эхийн боловсролын түвшин хүүхдийн голч дүнгийн хооронд статистик шинжилгээ хийж үзэхэд мөн хамааралгүй байна.

Зураг 14. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн боловсролын түвшин /хувиар/



Зураг 15. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэргэжлийн салбар, чиглэл /хувиар/



Асран хамгаалагчийн боловсрол: 49.5 хувь нь дээд боловсролтой; 26.4 хувь нь бүрэн дунд; 14.3 хувь нь техник мэргэжлийн; 4.3 хувь нь бага; 3.3 хувь нь огт боловсрол эзэмшээгүй байна.

Асран хамгаалагчийн эрхэлж буй хөдөлмөрийн салбар: 18.1 хувь нь боловсролын салбарт; 14.5 хувь нь бизнес удирдлага, эрх зүйн салбарт; 12 хувь нь үйлчилгээ, спорт, цэрэг, батлан хамгаалахын болон ХАА, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг, газар тариалангийн салбарт; 9.6 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт; 4.8 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик; худалдаа, нийтийн хоол; мэдээлэл харилцаа, холбооны салбарт; 1.2 хувь нь худалдааны салбарт тус тус ажиллаж байна.

Эцэг, эх, асран хамгаалагчдын боловсролын түвшнийг харьцуулан авч үзэхэд аль нэг нь дээд боловсрол эзэмшсэн хувь нь 43.5 хувь бөгөөд эцгийн дээд боловсрол эзэмшсэн хувь

хамгийн бага агаад эсрэгээр эхийн дээд боловсрол эзэмшсэн хувь өндөр байна. Мөн техник мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүний хувь эцгийн хувьд хамгийн өндөр, асран хамгаалагчийнх удаах бөгөөд эхийн хувьд хамгийн бага хувьтайгаар энэхүү боловсролыг эзэмшжээ. Харин боловсролгүй буюу огт боловсрол эзэмшээгүй хүний хувь эцэг болон эхэд ижил хувьтай буюу 1.2 хувь байсан бол боловсрол эзэмшээгүй асран хамгаалагчдын хувь 3.3 өндөр байлаа. Эцэг, эх, асран хамгаалагчдын ажил эрхлэлтийн байдлыг салбараар авч үзэхэд эцгийн болон асран хамгаалагчдын тус бүр 1.2 хувь нь тэтгэвэрт гарсан бол эхийн 1.1 хувь нь тэтгэвэрт гарсан бөгөөд харьцаа ижил байв. Харин ажил эрхэлж буй нийт асран хамгаалагч болон эхийн ихэнх хувь нь боловсрол, бизнесийн удирдлага, үйлчилгээ, спорт, цэрэг, батлан хамгаалахын салбарт ажиллаж байна. Харин эцгийн хувьд инженерчлэл, үйлдвэрлэл, барилга, бизнес, удирдлага, эрх зүйн салбарт ажиллаж байна.


Харин эцгийн, эхийн, асран хамгаалагчийн боловсролын түвшний хооронд шууд хамааралтай болох нь статистик шинжилгээний үр дүнгээс (хүснэгт 1) гарав. Өөрөөр хэлбэл, эхийн боловсролын түвшин өндөр байх тусам эцгийн боловсролын түвшин мөн адил өндөр; эцгийн болон эхийн боловсролын түвшин өндөр байх тусам асран хамгаалагчийн боловсролын түвшин өндөр байгаа нь хамаарлын шинжилгээний үр дүнгээс гарлаа.

Хүснэгт 3. Голч дүн болон эцэг, эх, асран хамгаалагчийн боловсролын түвшин хоорондын хамаарлын шинжилгээний үр дүн

			Эцгийн боловсролын түвшин	Эхийн боловсролын түвшин	Голч дүн
Spearman's rho	Эцгийн боловсролын түвшин	Correlation Coefficient		.456**	-.039
		Sig. (2-tailed)		.000	.385
		N		490	497
	Эхийн боловсролын түвшин	Correlation Coefficient			.037
		Sig. (2-tailed)			.408
		N			502
	Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн боловсролын түвшин	Correlation Coefficient	.581**	.475**	.036
		Sig. (2-tailed)	.000	.000	.735
		N	84	88	91

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Зураг 16. Судалгаанд оролцогчдын голч дүнгийн харьцаа /хувиар/



Оюутнуудын сурлагын амжилт, сурах үйл явцын чанарын үзүүлэлтийн нэг болох голч дүнгийн үзүүлэлтийг бүлэглэн үзүүлэв. Үүнээс харахад 49.7 хувь нь 3.0-3.4 голчтой суралцаж буй бол 31.4 хувь нь 3.5-4.0 голчтой, 13.6 хувь нь 2.5-2.9 голчтой, үлдсэн хувь нь 2.4-с доош голчтой суралцаж байна.


Голч дүн хүйсийн хувьд ялгаа байгаа эсэхэд Mann-Whitney U шинжилгээ хийхэд эмэгтэй оюутнууд эрэгтэйчүүдээс илүү сайн сурч байна ($U=24287.5$; $P=0.000$).

Оюутнуудын голч дүнг сурч байгаа сургуулийн хувьд ялгаатай байгаа эсэхэд статистик (One-way ANOVA, хүснэгт 4) шинжилгээ хийхэд ялгаатай үр дүн гарлаа. Шинжилгээний үр дүнд дахин нарийвчилсан харьцуулалтыг хийхэд ДХИС-д сурч байгаа оюутнуудын голч дүн АШУУИС, СЭЗИС-ийн оюутнуудаас илүү өндөр байна. Бусад сургуулиудын хувьд ялгаатай байдал илрээгүй болно.

Хүснэгт 4. Оюутны голч дүн ба сургуулиудын хоорондын ялгаа

ANOVA					
	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Between Groups	16.194	7	2.313	3.287	.002
Within Groups	354.045	503	.704		
Total	370.239	510			


Зураг 17. Их, дээд сургуульд сурдаг гэр бүлийн гишүүд /хувиар/



Нийт оролцогчдын гэр бүлийн гишүүдээс дор хаяж 2 хүн нь дээд боловсрол эзэмшсэн хувь 31.4; 3 хүн дээд боловсрол эзэмшсэн хувь 25.7 хувь; 4 хүн дээд боловсрол эзэмшсэн хувь 7.2 хувь; огт дээд боловсрол эзэмшээгүй 5.1 хувь байв.

Суралцаж буй мэргэжлийн сонголтод хэн нөлөөлсөн талаарх асуултад оюутнуудын 57.4 хувь нь өөрийн хүсэл сонирхлоор; 31 хувь нь гэр бүлийнхний зөвлөмж, туслалцаагаар; 5.5 хувь нь өөрийн хүссэн мэргэжлээрээ сурдаггүй гэжээ. Үүнээс үзэхэд судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь өөрсдийн хүсэл сонирхлоороо мэргэжлээ сонгосон нь харагдаж буй ч нөгөөтээгүүр бусдын нөлөөгөөр жишээлбэл 0.2 хувь нь багшийн; 2.4 хувь нь бусад хүмүүсийн нөлөөлөлд оржээ. Мэргэжлээ сонгохдоо ажил мэргэжлийн зөвлөхөөс зөвлөгөө авсан оюутнуудын хувь үнэмлэхүй бага байна.

Зураг 18. Мэргэжил сонголтод хэн нөлөөлсөн талаар /хувиар/



Хүснэгт 5. Мэргэжил сонголт ба эцгийн боловсролын түвшин

		Найз нөхөд	Өөрийн сонирхол	Ажил мэргэжлийн зөвлөх	Багш	Гэр бүл
Боловсролгүй	Эцгийн		50.00%			16.70%
	Эхийн		33.30%			16.70%
	Асран хамгаалагчийн		33.30%			
Бага боловсрол	Эцгийн		50.00%			30.00%
	Эхийн		60.00%			20.00%
	Асран хамгаалагчийн					100.00%
Бүрэн бус дунд	Эцгийн		54.30%		2.90%	28.60%
	Эхийн		50.00%		6.30%	37.50%
	Асран хамгаалагчийн		50.00%			
Бүрэн дунд	Эцгийн	1.30%	68.20%	0.70%	2.00%	21.20%
	Эхийн	0.90%	71.00%	0.90%	2.80%	18.70%
	Асран хамгаалагчийн		75.00%		4.20%	
Мэргэжлийн боловсрол	Эцгийн	1.30%	48.70%		5.30%	38.20%
	Эхийн		58.30%		3.30%	33.30%
	Асран хамгаалагчийн		69.20%			
Дээд	Эцгийн		52.80%		1.40%	38.30%
	Эхийн	0.70%	53.80%		1.70%	36.00%
	Асран хамгаалагчийн		47.70%		2.30%	

Судалгаанд оролцсон оюутнууд мэргэжлээ сонгохдоо, дийлэнх нь өөрийн сонирхлоор сонгосон байна. Тэднийг мэргэжил сонгоход өөрийн сонирхлоос гадна гэр бүлийн нөлөө харьцангуй их байсныг судалгааны үр дүн харууллаа.

Хүснэгт 6. Эцгийн ажилладаг салбар ба сургалтын төлбөр төлдөг хэлбэрүүд

Эцгийн эрхэлдэг ажлын салбар	Боловсролын сангийн зээл	Бусад зээл	Бүцэлтгүй тусламж	Өөрөө ажил хийж	Тэтгэлэг	Хадгаламж	Эцэг эхийн цалин
Бизнес, удирдлага, эрх зүй	5.2%	2.1%		6.3%	7.3%	3.1%	76.0%
Үйлчилгээ, спорт, цэрэг, батлан хамгаалах	5.0%	2.5%	1.3%	7.5%	2.5%	3.8%	77.5%
Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга	2.8%	0.9%	1.9%	12.3%	5.7%	2.8%	73.6%
ХАА, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг	4.8%	8.1%		4.8%	8.1%		74.2%
Боловсрол	5.0%			15.0%	15.0%	5.0%	60.0%
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	10.0%	10.0%		10.0%	30.0%		40.0%
Нийгмийн шинжлэх ухаан, сэтгүүл зүй	14.3%			14.3%	28.6%		42.9%
Уул уурхай	7.7%	7.7%	7.7%		15.4%		61.5%
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	5.9%	11.8%		11.8%	11.8%	5.9%	52.9%
Төрийн байгууллага				33.3%			66.7%
Тэтгэвэр				50.0%			50.0%
Урлаг, хүмүүнлэг				16.7%	33.3%		50.0%
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик					16.7%		83.3%
Жолооч		14.3%					85.7%
Санхүү, нягтлан бодох бүртгэл							100.0%
Эдийн засаг							100.0%

Хүснэгт 7. Эхийн ажилладаг салбар ба сургалтын төлбөр төлдөг хэлбэрүүд

Эхийн эрхэлдэг ажлын салбар	Боловсролын сангийн зээл	Бусад зээл	Бүцэлтгүй тусламж	Өөрөө ажил хийж	Тэтгэлэг	Хадгаламж	Эцэг эхийн цалин
Бизнес, удирдлага, эрх зүй	3.2%			5.3%	7.4%	3.2%	81.1%
Үйлчилгээ, спорт, цэрэг, батлан хамгаалах	1.5%	7.5%		13.4%	4.5%		73.1%


Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга	5.9%	8.8%		23.5%	2.9%	2.9%	55.9%
ХАА, ой, загасны аж ахуй, мал эмнэлэг		2.9%		11.8%	11.8%		73.5%
Боловсрол	3.1%	3.1%	2.1%	6.3%	13.5%	2.1%	69.8%
Мэдээлэл, харилцаа холбооны технологи				13.3%		6.7%	80.0%
Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	8.9%	5.4%		8.9%	3.6%	3.6%	69.6%
Төрийн байгууллага							100.0%
Тэтгэвэр		20.0%		40.0%			40.0%
Урлаг, хүмүүнлэг				16.7%			83.3%
Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик			33.3%		16.7%		50.0%
Санхүү, нягтлан бодох бүртгэл	50.0%				50.0%		
Эдийн засагч							100.0%
Банк	50.0%			50.0%			
Гадаадад							100.0%
Малчин	12.5%	18.8%			12.5%		56.3%
Нарийн боовч							100.0%
Оёдолчин	50.0%						50.0%
Тогооч		50.0%					50.0%
Төмөр зам							100.0%
Төрийн бус байгууллага	50.0%						50.0%

Хүснэгт 8. Өрхийн орлого ба их, дээд сургуульд сурсан гэр бүлийн гишүүдийн тоо

	1 саяас доош	1-2 сая	2-3 сая	3 саяас дээш	Орлогогүй	Тогтворгүй
1	48.8%	33.6%	25.4%	12.6%	0.0%	28.6%
2	27.9%	26.4%	35.8%	34.1%	50.0%	28.6%
3	4.7%	15.2%	20.9%	37.8%	50.0%	14.3%
4	9.3%	7.2%	6.7%	6.7%	0.0%	0.0%
5	0.0%	4.0%	4.5%	4.4%	0.0%	14.3%
5-аас дээш	2.3%	4.0%	3.7%	3.0%	0.0%	0.0%


Дээрх хүснэгтээс харахад, их, дээд сургуульд сурдаг гэр бүлийн гишүүний тоо 1-3 байх тохиолдолд өрхийн орлоготой төдийлөн хамаарал байхгүй байна.

Зураг 21. Сургалтын төлбөрийн асуудлаас үүдэн сургууль завсардсан эсэх /хувиар/



Судалгаанд оролцогчдын 90.7 хувь нь сургалтын төлбөрийн асуудлаас болж сургууль завсардаагүй бол 9.3 хувь нь завсардаж байжээ.

Зураг 22. Сургалтын төлбөрөө төлдөг хэлбэр /хувиар/




Зураг 23. Сургалтын төлбөртэй холбоотой хүндрэл /хувиар/



Судалгаанд оролцогч оюутнуудын 69.1 хувь нь буюу дийлэнх олонх нь эцэг эхийн цалингаар төлбөрөө төлдөг бол 9.8 хувь нь өөрөө ажил хийж, 8.3 хувь нь тэтгэлэгт хамрагдан, 4.5 хувь нь боловсролын зээлийн сангаас зээлээр, 1.8 хувь нь буцалтгүй тусламжид хамрагддаг байна. Сургалтын төлбөрөө төлөхөд оюутнуудын 21.9 хувьд нь асуудалгүй, 28.8 хувьд нь хүндрэлтэй ба маш хэцүү байна. Өөрөөр хэлбэл 3 оюутан бүрийн 1-д сургалтын төлбөрөө төлөхөд хэцүү байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа.

Зураг 24. Сургалтын төлбөрөө төлдөг хэлбэр ба төлөхөд хэцүү байдал /хувиар/



Судалгааны үр дүнгээс харахад, эцэг эхийн цалингаараа сургалтын төлбөрөө төлөхөд маш хэцүү болон хүндрэлтэй байгаа нь талаас илүү хувийг эзэлж байна. Үүний дараагаар өөрөө ажил хийж болон зээлээр сургалтын төлбөрөө төлөхөд маш хэцүү болон хүндрэлтэй байна гэжээ. Сургалтын төлбөр төлөхөд хүндрэлгүй байдаг гэж хариулсан оюутнуудын 70 орчим хувийг эцэг эх нь цалингаасаа төлдөг бол үүний дараагаар өөрсдөө ажил хийж, тэтгэлэг авч сургалтын төлбөрөө төлдөг байна.


Хүснэгт 9. Сургууль ба төлбөр төлөх хэлбэр

	Боловсролын сангийн зээл	Бусад зээл	Буцалтгүй тусламж	Өөрөө ажил хийж	Тэтгэлэг	Хадгаламж	Эцэг эхийн цалин
МУИС	21.7%	13.6%	11.1%	18.4%	21.4%	9.1%	16.3%
АШУУИС	8.7%	36.4%	44.4%	20.4%	23.8%	36.4%	30.4%
СЭЗИС	43.5%	4.5%	11.1%	16.3%	11.9%	18.2%	24.6%
ДХИС	17.4%	27.3%	22.2%	20.4%	16.7%	9.1%	20.1%
ШУТИС	4.3%	9.1%	0.0%	10.2%	7.1%	9.1%	3.4%
ХААИС	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.6%
МУБИС	0.0%	4.5%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.6%
Бусад их сургууль	4.3%	4.5%	11.1%	14.3%	19.0%	18.2%	4.0%

Сургалтын төлбөрөө төлдөг хэлбэрийг сургуулиар нь харьцуулан харуулахад, Боловсролын сангийн зээлд СЭЗИС-ийн оюутнууд хамгийн их хамрагддаг бол дараагаар нь МУИС, ДХИС-ийн оюутнууд орж байна. Буцалтгүй тусламжид АШУУИС-ийн оюутнууд хамгийн их хамрагджээ. Бусад тэтгэлэг авсан оюутнуудын дийлэнх нь МУИС, АШУУИС болон ДХИС байна. Үүнд Ерөнхийлөгчийн, Ерөнхий сайдын, ОУ-ын байгууллага, бусад байгууллагын тэтгэлгээс гадна дээрх гурван сургуулийн дотоодын тэтгэлгүүд цөөнгүй байгааг харуулж байна.

ШУТИС, ХААИС, МУБИС-ийн оюутнуудын түүврийн тоо хангалттай хэмжээнд хүрээгүй тул дээрх 3 сургуулийн судалгааны үр дүнг дүгнэж ярих боломжгүйг анхаарна уу.

Зураг 25. Ажил хийдэг эсэхийг сургуулиар нь харьцуулбал /хувиар/




АШУУИС-ийн судалгаанд хамрагдсан оюутнуудын 60 хувь нь ажил хийдэггүй байна. Энэ нь магадгүй тухайн мэргэжлийн хичээлийн ачаалал, онцлогтой холбоотой байх магадлалтай юм.

ШУТИС, ХААИС, МУБИС-ийн оюутнуудын түүврийн тоо хангалттай хэмжээнд хүрээгүй тул дээрх 3 сургуулийн судалгааны үр дүнг дүгнэж ярих боломжгүйг анхаарна уу.

7 хоногт ажиллаж байгаа цагийг хүйсийн хувьд ялгаа байгаа эсэхэд статистик шинжилгээ (One-way ANOVA) хийхэд эрэгтэй оюутнууд эмэгтэйчүүдээс илүү олон цаг ажиллаж байна ($F=8.990$; $P=0.000$).


Зураг 26. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн цаг /хувиар/



Сургалтын төлбөрөөс гаднах зардлуудыг төлөхөд 65.5 хувьд нь хүндрэлтэй байдаг ба нийт оюутнуудын 47.6 хувь нь хичээлийн хажуугаар ажил хөдөлмөр эрхэлдэг байна. Ажил хийдэг оюутнуудын 12.9 хувь нь 10-с доош цаг, 15.3 хувь нь 10-20 цаг, 8.9 хувь нь 20-30 цаг, 10.5 хувь нь 30-аас дээш цаг 7 хоногт ажилладаг байна.


Судалгаанд оролцогчдын голч дүнг ажил хийдэг эсэх мөн ажил хийдэг цагтай нь харьцуулахад дараах үр дүн гарлаа.

Зураг 27. Голч дүн ба ажил хийдэг цаг /хувиар/



Дээрх үр дүнгээс харахад, 2.0-оос доош голчтой оюутнуудын тал хувь нь 7 хоногт 30-аас дээш цаг ажиллаж байна.

Зураг 28. Голч дүн ба ажил хийдэг эсэх



Ажилхийдэг оюутнуудын эзлэх хувь хэмжээ ихсэх тусам голч дүн буурч байгаа нь судалгааны үр дүнгээс гарч байна.

Дараах хүснэгтээс оюутнуудын сургалтын төлбөрөө төлж байгаа хэлбэрүүд болон өрхийн орлогын мэдээллийг харж болно.

Хүснэгт 10. Өрхийн орлого ба төлбөр төлөлтийн хэлбэр

	1 саяас доош	1-2 сая	2-3 сая	3 саяас дээш	Тогтворгүй
Боловсролын сангийн зээл	17.6%	35.3%	5.9%	41.2%	0.0%
Бусад зээл	22.2%	38.9%	22.2%	11.1%	5.6%
Буцалтгүй тусламж	33.3%	44.4%	11.1%	11.1%	0.0%
Өөрөө ажил хийж	12.8%	27.7%	27.7%	31.9%	0.0%
Тэтгэлэг	17.1%	28.6%	28.6%	25.7%	0.0%
Хадгаламж	0.0%	10.0%	60.0%	30.0%	0.0%
Эцэг эхийн цалин	6.9%	27.1%	32.4%	31.0%	2.7%


Өрхийн орлогын хэмжээ бага байх тусам буцалтгүй тусламжид хамрагдсан оюутны тоо харьцангуй их байна.

Хүснэгт 11. Сургалтын төлбөр төлөх хүндрэл ба нийгмийн гарал

Сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэлтэй эсэх	Нийгмийн гарал суралцах үйл явцад		
	Нөлөөлдөг	Нөлөөлдөггүй	Мэдэхгүй
Асуудалгүй	12.8%	64.2%	22.9%
Бага зэрэг	14.5%	63.4%	22.1%
Дунд	12.6%	65.0%	22.3%
Маш хэцүү	22.0%	55.6%	22.4%

Судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх нь нийгмийн гарал үүсэл суралцах явцад нөлөөлдөггүй гэж хариулжээ.

Зураг 29. Сургалтын төлбөрөөс гадуурх зардал хүндрэлтэй байдал



Судалгааны үр дүнгээс харахад, 65.5 хувь нь сургалтын төлбөрөөс бусад зардлуудыг төлөхөд хүндрэлтэй байдаг гэсэн байна. Оюутнууд ажил хийдэг ч гэсэн сургалтын төлбөрөөс бусад амьдралын зардлуудыг төлөхөд хүндрэлтэй байна гэж талаас илүү хувь нь хариулжээ.


Сургалтын төлбөрөөс гадна байрны түрээс, хоол зэрэг нэмэлт зардлыг одоо амьдарч байгаа газартай нь харьцуулж үзэхэд дараах үр дүн гарлаа.

Хүснэгт 12. Нэмэлт зардал ба амьдарч буй газар

Хоол, түрээс зэрэг нэмэлт зардлуудыг төлөхөд хүндрэлтэй эсэх	Одоо амьдарч буй газар				
	Гэртээ	Найзын гэр	Оюутны байр	Түрээсийн байр	Хамаатны гэр
Хүндрэлтэй	59.5%	0.6%	10.1%	14.0%	13.4%
Хүндрэлгүй	79.2%	0.0%	6.9%	3.5%	10.4%

Цаашид суралцахад хүндрэлтэй асуудлууд байсаар байна хэмээн 32.1 хувь нь, харин үгүй хэмээн 39.4 хувь нь хариулжээ. Цаашид суралцахад хүндрэлтэй байгаа оюутнуудаас шалтгааныг тодруулахад 61 хувь нь хувь хүнтэй холбоотой; 18 хувь нь сургуулийн орчин нөхцөлтэй холбоотой; 12 хувь нь багш нартай холбоотой, 9 хувь нь бусад асуудлууд байна.

Зураг 30. Цаашид суралцахад хүндрэлтэй асуудлууд байх эсэх /хувиар/



Зураг 31. Цаашид суралцахад хүндрэлтэй байгаа шалтгаан



Хүснэгт 13. Суралцахад гарч байгаа хүндрэл, бэрхшээлүүд

Хүндрэл, бэрхшээлүүд	Эзлэх хувь хэмжээ
Хувь хүнтэй холбоотой асуудал	60.2
Санхүүгийн хүндрэлтэй байдал	40.5
Ажлын ачаалал	6.6
Сэтгэл зүйн асуудлууд	4.7
Гэрийн асуудал	3.8
Эрүүл мэндийн асуудал	1.9
Ажил хийх боломжгүй	.9
Хоцрогдол	.9
Хүүхэд төрүүлсэн	.9
Сургуулийн орчинтой холбоотой асуудал	17.7
Орчин нөхцөл, харилцаа	5.6
Хичээлийн хуваарь маш асуудалтай	4.7
Номын сан, төхөөрөмжийн хүрэлцээ бага	2.8

Интернэт хүрэлцээ	1.9
Боловсролын хүртээмж /төлбөрөө төлж сурч байгаа ч ялгаварлагдах/	.9
Сургалтын албаны хүнд суртал	.9
Сургалтын хөтөлбөр сайжруулах	.9
Багш нартай холбоотой асуудал	11.2
Багш нарын ааш зан, хүнд суртал ялгаварлан гадуурхал, сургах арга барил, сургалтын систем	7.5
Багш нарын харилцаа хандлага, аливаа зүйлсийн цагийг нь тулгаж хэлдэг зохион байгуулалт маш муу	2.8
Харилцааны соёл	.9
Бусад	9.4
Өөр олон зүйлс	3.8
Замын түгжрэл	2.8
Монголын нөхцөл байдал	2.8

Дээрх шалтгаануудаас хамгийн их хувийг санхүүгийн асуудал эзэлж байгаа бол үүний дараагаар багш нарын харилцаа, хандлага, ялгаварлан гадуурхал, сургуулийн орчин нөхцөл, ачаалал зэрэг болно.

Хүснэгт 14. Цахим хичээлд хамрагдах нөөц, бололцоог ажил хийдэг эсэх болон нэмэлт зардалтай харьцуулсан байдал

Ажил хийдэг эсэх	Сургалтын төлбөрөөс гадна нэмэлт зардал төлөхөд хүндрэлтэй эсэх	Цахим хичээлд хамрагдах нөөц, бололцоо (Гар утас, зөөврийн компьютер, интернэт, суурин компьютер, сүлжээ)		
		Дунд	Сайн	Муу
Ажил хийдэггүй	Тийм	20.7%	74.5%	4.8%
	Үгүй	6.1%	93.0%	0.9%
10-аас доош цаг ажилладаг (7 хоногт)	Тийм	32.0%	62.0%	6.0%
	Үгүй	20.0%	80.0%	0.0%
10-20 цаг ажилладаг (7 хоногт)	Тийм	24.1%	66.7%	9.3%
	Үгүй	18.2%	81.9%	0.0%
20-30 цаг ажилладаг (7 хоногт)	Тийм	26.7%	70%	3.3%
	Үгүй	8.3%	91.6%	0.0%
30-аас дээш цаг ажилладаг (7 хоногт)	Тийм	33.3%	44.4%	22.2%
	Үгүй	12.5%	87.5%	0.0%

7 хоногт 30-аас дээш цаг ажилладгаас бусад нь цахим хичээлд хамрагдах техник хэрэгсэл, интернэтийн боломж сайтай оюутнууд 60 хувиас илүү байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа. Тиймээс их, дээд сургуулиуд цахимаар хичээл ороход оюутнуудын хамрагдах байдал харьцангуй сайн боломжтой байна.


Дэд бүлгийн дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан оюутнуудын 69.8 хувийн өрхийн орлого 3 саяас доош төгрөг байна.
- Өрхийн орлого буурах тусам хамаатныдаа болон оюутны байранд амьдарч байгаа оюутнууд тоо ихсэж байна. Судалгааны үр дүнгээс харахад, оюутны байранд амьдарч байгаа оюутны тоо цөөн байгаа нь оюутны байрны хүрэлцээ төдийлөн хангалттай биш байна гэж дүгнэхээр байна.
- Их, дээд сургуульд сурдаг гэр бүлийн гишүүний тоо 1-3 байх тохиолдолд өрхийн орлоготой төдийлөн хамаарал байхгүй байна.
- Судалгаанд оролцсон 3 оюутан бүрийн 1-д сургалтын төлбөрөө төлөхөд хэцүү байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа.
- Сургалтын төлбөрийг эцэг эхийн цалингаар, тэтгэлгээр, өөрөө ажил хийх байдлаар төлдөг байна.
- Боловсролын сангийн зээлд СЭЗИС-ийн оюутнууд хамгийн их хамрагддаг бол дараагаар нь МУИС, ДХИС-ийн оюутнууд орж байна. Судалгаанд оролцогчдын өрхийн орлого гурван саяас дээш тохиолдолд 40 орчим хувь нь боловсролын зээлд хамрагджээ. Боловсролын зээл авах гол шалгуур нь голч дүнгийн үзүүлэлт байдаг. Гэтэл голч дүн нь оюутнуудын ажил эрхлэлттэй хамааралтай байсан ба ажил хийх цаг их байх тусам голч дүн буурч байсан. Харин гурван саяас дээш өрхийн орлоготой оюутнуудын ажил хийх цаг бага, голч дүн өндөр байгаа нь боловсролын зээлд хамрагдах шаардлагыг хангаж байна.
- Буцалтгүй тусламжид АШУҮИС-ийн оюутнууд хамгийн их хамрагджээ. Тэтгэлэг авсан оюутнуудын дийлэнх нь МУИС, АШУҮИС болон ДХИС байна. Тиймээс Ерөнхийлөгчийн, Ерөнхий сайдын, ОУ-ын байгууллага, бусад байгууллагын тэтгэлгээс гадна дээрх гурван сургуулийн дотоодын тэтгэлгүүд цөөнгүй байгааг харуулж байна.
- АШУҮИС-ийн оюутнуудын 60 хувь нь ажил хийдэггүй бол, МУИС, СЭЗИС-ийн оюутнуудын талаас илүү хувь нь ажил хийдэг байна. Энэ нь суралцаж байгаа мэргэжлийн онцлог, хичээлийн ачаалалтай холбоотой байх магадлалтай юм.
- 7 хоног хийх ажлын цаг ихсэх тусам голч дүн буурч байгаа нь судалгааны үр дүнгээс гарлаа.
- Судалгааны үр дүнгээс харахад, 65.5 хувь нь сургалтын төлбөрөөс бусад зардлуудыг төлөхөд хүндрэлтэй байдаг гэсэн ба оюутнууд ажил хийдэг ч зардлуудаа төлөхөд мөн л хүндрэлтэй байна гэж талаас илүү хувь нь хариулжээ.
- Цаашид суралцахад хүндрэлтэй байдаг хамгийн том асуудал бол санхүүгийн асуудал байгаа нь судалгааны үр дүнгээс гарсан. Үүний дараагаар нэг их хувийг эзлээгүй ч багш нарын харилцаа, хандлага, ялгаварлан гадуурхал, сургуулийн орчин нөхцөлийн тааруу байдал, хичээл болон ажлын ачаалал зэрэг шалтгаанууд орж байна.
- Оюутнуудын дийлэнх нь цахим хичээлд хамрагдах техникийн нөөц бололцоотой байна.
- Цагийн ажлыг эрэгтэй оюутнууд эмэгтэйчүүдээс илүү их хийдэг нь судалгааны үр дүнгээс гарлаа.


2.4 Сургалт, мэдээллийн тэгш хүртээмжийг судалсан үр дүн

Нийт судалгаанд оролцогчид бүгд ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхалтад өртөж байсан ба дийлэнх нь буюу 48.9 хувь нь гадаад дүр төрхөөр, 34.7 хувь нь хот болон орон нутгийн байдлаар, 25.9 хувь нь нутгийн аялгаар, 16.3 хувь нь нийгмийн гарал үүслээр, 16 хувь нь үндэс угсаагаар, 14.3 хувь нь бэлгийн чиг хандлагаар, 8.6 хувь нь шашин шүтлэгээр, 4.7 хувь нь хөгжлийн бэрхшээлээр, 26.8 хувь нь бусад шалтгаанаар ялгаварлан гадуурхагдаж байжээ.

Зураг 32. Гадуурхалтад өртөж байсан эсэх



Зураг 33. Нийгмийн гарал суралцах үйл явцад нөлөөлдөг эсэх /хувиар/



Судалгаанд оролцогчдын нийгмийн гарал, үүсэл нь өөрсдийн суралцах явцад нөлөөлж буй эсэхийг тодорхойлоход 15.7 хувь нь буюу 80 орчим оюутан нөлөөлж байна хэмээн үзсэн бол 62.2 хувь нь үгүй, харин 22.2 хувь нь мэдэхгүй хэмээн хариулжээ.

Нийгмийн гарал үүсэл нь тэдний суралцах үйл явцад нөлөөлж байна хэмээн хариулсан оролцогчдоос ямар хэлбэрээр нөлөөлж буйг тодруулахад 22.2 хувь нь нийгмийн давхаргын ялгаа үүсгэхэд; 13.3 хувь нь багш нарын үнэлгээ, хандлагад; 8.9 хувь нь мөнгөтэй эсэхээр, 6.7 хувь нь хөдөө, орон нутгаар, гадаад төрхөөр ялгаварлан гадуурхагддаг гэжээ.


Хүснэгт 15. Ялгаварлан гадуурхагдаж байгаа хэлбэр /хувиар/

1	Нийгмийн давхаргын ялгаа	22.2
2	Багш нар орон нутгаар ялгаварладаг	13.3
3	Мөнгөтэй эсэхээр	8.9
4	Хөдөө, орон нутгаар ялгаварлах	6.7
5	Гадаад төрх харах	6.7
6	Олон хэлбэрээр	6.6
7	Яс үндэс	4.4
8	Хүрээлэлд багтаж чадахгүй байх	4.4
9	Оюутнууд нэгнээ гадуурхах	2.2


10	Суралцах боломжид нөлөөлдөг	2.2
11	Тэтгэлэг авахад өрхийн орлого бага, хөдөө орон нутаг байхыг шаарддаг	2.2
12	Өнчин болохоор ялгаварлах	2.2
13	Хэлж мэдэхгүй байна	2.2

Их дээд сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй оюутны асуудлыг хэр түвшинд авч үздэгийг тодруулахад, сургуульд нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан тусгай мэргэжилтэн байхгүй гэж 32.9 хувь нь, байдаг гэж 7.5 хувь нь хариулсан байна. Үлдсэн судалгаанд оролцогчид энэ талаар мэдээлэлгүй байлаа. Хичээлийн явцад хичээл зааж буй багш тухайн тусгай хэрэгцээт оюутанд тохируулан хичээлээ заадаг хэмээн 12.2 хувь нь; үгүй гэж 26.5 хувь нь; харин 61.2 хувь нь энэ талаар мэдээлэлгүй байна.

Зураг 34. Хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтэнтэй эсэх /хувиар/



Зураг 35. Багш хөгжлийн бэрхшээлтэй оюутанд тохирсон арга барил ашигладаг эсэх /хувиар/



Судалгаанд оролцсон оюутнууд сургууль дээр нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтэн байдаг эсэхийг ихэнх нь мэдэхгүй байна. Нэг талаас судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй оюутны төлөөлөл оролцоогүй байх магадлалтай тул үр дүнд нөлөөлсөн байх. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааны талаарх мэдээллийг оюутнууд төдийлөн мэддэггүйтэй холбоотой байх магадлалтай. Тухайлбал МУИС-д хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтэн ажилладаг боловч МУИС-ийн оюутнуудын 62.1 хувь мэдэхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 16. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан хариуцсан мэргэжилтэн байдаг эсэх

	МУИС	АШУУИС	СЭЗИС	ДХИС
Тийм	19.5%	1.4%	1.0%	4.5%
Үгүй	18.4%	23.2%	61.4%	32.4%
Мэдэхгүй	62.1%	75.4%	37.6%	63.1%

Хүснэгт 17. Ялгаварлан гадуурхагдаж байсан шалтгаанууд ба сургууль /хувиар/

	Үндэс угсаа	Аялга	Бэлгийн чиг хандлага	Гадаад төрх	Нийгмийн гарал	Хот, орон нутаг	Хөгжлийн бэрхшээл	Шашин шүтлэг
АШУУИС	22	4.6	5.5	19.3	9.2	22	0.9	1.8
ДХИС	13.5	7.4	2.5	23.5	11.1	19.7		1.23
МУИС	12.6	3.8	2.5	21.5	15.2	25.3		
СЭЗИС	9.5	4.2	1.05	28.4	7.4	20		3.1

Судалгаанд оролцсон АШУУИС, МУИС, ДХИС, СЭЗИС-ийн оюутнуудын хувьд гадаад төрх, үндэс угсаа, нийгмийн гарал, хот орон нутгаар ялгаварлан гадуурхагдаж байсан нь судалгааны үр дүнгээс гарав. Тиймээс дээрх 4-н сургуульд энэ хэлбэрийн ялгаварлан гадуурхал байх магадлал өндөр байна.

ШУТИС, ХААИС, МУБИС-ийн оюутнуудын түүврийн тоо хангалттай хэмжээнд хүрээгүй тул 3 сургуулийн судалгааны үр дүнг дүгнэж ярих боломжгүйг анхаарна уу.

Хүснэгт 18. Ялгаварлан гадуурхал суралцах үйл явцад нөлөөлдөг эсэх /хувиар/


	МУИС	АШУУИС	СЭЗИС	ДХИС	Хэдийгээр ялгаварлан гадуурхалтад өртөж байсан боловч суралцах үйл явцад нөлөөлдөггүй гэж талаас илүү хувь нь хариулжээ. 3 сургуулийн хувьд, ойролцоогоор 5 оюутан тутмын 1 нь суралцах үйл явцад нөлөөлдөг гэсэн байна.
Тийм	20.7	19.4	18.6	7.9	
Үгүй	57.5	62.5	60.2	64.4	
Мэдэхгүй	21.8	18.1	21.2	27.7	

Хүснэгт 19. Ялгаварлан гадуурхал ба хүйс /хувиар/


	Үндэс угсаа	Аялга	Бэлгийн чиг хандлага	Гадаад төрх	Нийгмийн гарал	Хот, орон нутаг	Хөгжлийн бэрхшээл	Шашин шүтлэг
Эрэгтэй	18	3	1.8	22.9	7.2	15		3
Эмэгтэй	13.3	3.8	2.3	21.6	10.2	22.7		1.5
Бусад		25	25	25			25	

Эрэгтэй оюутнууд гадаад төрх, үндэс угсаа, хот орон нутгаасаа шалтгаалан ялгаварлан гадуурхалт өртөж байсан бол эмэгтэй оюутнууд хот орон нутаг, гадаад төрхөөрөө ялгаварлан гадуурхалт өртөж байсан байна.

Зураг 36. Тэтгэлгийн мэдээллийн хүртээмжтэй байдал /хувиар/




Зураг 37. Оюутны холбоо, клубээс зохион байгуулдаг үйл ажиллагааны хүртээмжтэй байдал /хувиар/




Сургалтын тэтгэлэг, оюутны байгууллагуудын үйл ажиллагааны мэдээлэл нь тэгш бөгөөд хүртээмжтэй эсэхийг тодруулахад тэтгэлэг, тэмцээн, уралдааны талаарх мэдээллийг 40.4 хувь нь хүртээмжтэй байдаггүй, 44.9 нь хүртээмжтэй хэмээсэн ба оюутнуудын холбоо, клубээс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээллийн хүртээмжтэй байдлыг 11 хувь нь маш сайн, 31.6 хувь нь сайн, 38.2 хувь нь дунд, 10.2 хувь нь муу хэмээн үнэлжээ. Харин тэтгэлгийн шалгуурын тэгш бөгөөд хүртээмжтэй байдлыг 11 хувь нь муу, 30.1 хувь нь дунд, 28.9 хувь нь сайн, 23.2 хувь нь мэдэхгүй, 6.9 хувь нь маш сайн хэмээн үнэлсэн байна.


Зураг 38. Тэтгэлгийн шалгуур тэгш хүртээмжтэй байдаг эсэх /хувиар/



Зураг 39. Оюутны холбоо, клубээс зохион байгуулдаг үйл ажиллагааны хүртээмж ба сургууль /хувиар/




Зураг 40. Тэтгэлгийн мэдээллийн хүртээмж ба сургууль /хувиар/



АШУУИС, СЭЗИС-ийн оюутны клубээс зохион байгуулж байгаа ажлыг тус сургуулийн судалгаанд оролцсон оюутнуудын тал хувь нь хүртээмжтэй гэж үнэлжээ. Харин тэтгэлэг, уралдаан тэмцээний талаарх мэдээллийг судалгаанд оролцогчдын 40-47 хувь нь хүртээмжтэй гэж хариулжээ.

Зураг 41. Тэтгэлгийн шалгуур тэгш хүртээмж ба сургууль /хувиар/



СЭЗИС-ийн оюутнуудын талаас илүү хувь нь тэтгэлгийн шалгуурыг тэгш хүртээмжтэй гэж үзсэн бол бусад сургуулийн хувьд, 3-4 оюутан тутмын 1 нь шалгуурыг тэгш шударга гэж үзсэн байна. Тиймээс сургуулиуд тэтгэлгийн шалгуур үзүүлэлтээ дахин анхаарах хэрэгтэйг судалгааны үр дүн харууллаа.

Зураг 42. Их сургуулиудын орон нутаг дахь элсэлтийн тоо хүртээмжтэй эсэх /хувиар/



Орон нутаг дахь их дээд сургуулийн элсэлтийн хяналтын тоог хүртээмжтэй хэмээн 15.2 хувь нь үзсэн бол үгүй хэмээн 26.3 хувь нь үзэж 58.5 хувь нь энэ талаар мэдэхгүй байна. 5 оюутан бүрийн 1 нь орон нутагт хуваарилагддаг элсэлтийн хяналтын тоо хүртээмжгүй байдаг гэсэн тул их, дээд сургуулиуд орон нутаг дахь үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн онцлогийг харгалзах, хяналтын тоог нэмэх тал дээр анхаарч ажиллахыг хүсэж байна.

Хүснэгт 20. Орон нутаг дахь элсэлтийн хяналтын тооны хүртээмж ба сургууль

	Орон нутагт элсэлтийн хяналтын тоо хүртээмжтэй	Орон нутагт элсэлтийн хяналтын тоо хүртээмжгүй	Мэдэхгүй
МУИС	17.6	31.8	50.6
АШУУИС	19.7	25.4	54.9
СЭЗИС	14.3	13.4	72.3
ДХИС	9.8	40.2	50

Орон нутагт хуваарилагдаж байгаа элсэлтийн хяналтын тооны хүртээмжийг сургуулиар нь ялган харуулахад, МУИС, АШУУИС, ДХИС-д элсэхийг хүсэгчид нэлээдгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Дэд бүлгийн дүгнэлт

- Нийт судалгаанд оролцогчид бүгд ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхалтад өртөж байсан ба үүнийг дарааллаар нь харвал:

1. Гадаад дүр төрхөөр;
2. Хот болон орон нутгийн байдлаар;
3. Нутгийн аялгаар;
4. Нийгмийн гарал үүслээр;
5. Үндэс угсаагаар;
6. Бэлгийн чиг хандлагаар;
7. Шашин шүтлэгээр;
8. Хөгжлийн бэрхшээлээр тус тус ялгаварлан гадуурхагдаж байжээ.

Дээрх үр дүнгээс харахад, оюутнуудыг гадаад төрхөөр, орон нутгаар, нутгийн аялгаар ялгаварлан гадуурхаж байгаа нь дийлэнх байгааг цаашид их сургуулиуд анхаарах шаардлагатай байна.

- Судалгаанд оролцогчдын дийлэнх нь нийгмийн гарал, үүсэл нь тэдний суралцах явцад нөлөөлдөггүй гэжээ.
- Суралцах үйл явцад нөлөөлдөг гэж үзсэн оюутнууд нийгмийн давхаргын ялгаагаар,

багш нарын үнэлгээ, хандлагаар, мөнгөтэй эсэхээр, хөдөө, орон нутгаар, гадаад төрхөөрөө ялгаварлан гадуурхагддаг байна.

- Сургууль дээр нь хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтэн байдаг эсэхийг ихэнх нь мэдэхгүй байна. Энэ нь нэг талаас магадгүй манай судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй оюутны оролцоогүй, нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй оюутныг хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааг оюутнууд төдийлөн мэддэггүйтэй холбоотой гэж дүгнэж байна.
- Их, дээд сургуулийн оюутнуудын дунд гадаад төрх, үндэс угсаа, нийгмийн гарал, хот орон нутгаар ялгаварлан гадуурхал байна.
- Оюутны клубийн үйл ажиллагаа дийлэнх оюутнуудад хүрч чаддаг бол тэтгэлэг, тэмцээн, уралдааны талаарх мэдээлэл дийлэнх оюутныг хамарч чадахгүй байна.
- Зарим сургуулийн оюутнууд тэтгэлгийн шалгуур үзүүлэлтийг шударга, хүртээмжтэй гэж хариулсан хувь хэмжээ дийлэнх биш байгаа тул сургуулиуд тэтгэлгийн шалгуур үзүүлэлтээ дахин анхаарах хэрэгтэйг судалгааны үр дүн харууллаа.
- Орон нутаг дахь их дээд сургуулийн элсэлтийн хяналтын тоог хүртээмжгүй байна гэж хариулсан тул их, дээд сургуулиуд орон нутаг дахь үйлдвэрлэл, аж ахуйн нэгжийн онцлогийг харгалзах, хяналтын тоог нэмэх тал дээр анхаарч ажиллахыг хүсэж байна.

ШУТИС, ХААИС, МУБИС-ийн оюутнуудын түүврийн тоо хангалттай хэмжээнд хүрээгүй тул гурван сургуулийн судалгааны үр дүнг дүгнэж ярих боломжгүйг анхаарна уу.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Монгол улсын холбогдох хууль тогтоомжид дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын ... онд нэгдэн орсон хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1976 оны Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13(2)(с)-д тус бүр хүн бүр сурч боловсрох эрхтэй болон дээд боловсрол бүгдэд ижил хүртээмжтэй болгох ёстой хэмээн заасан байдаг ба 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна” гэсэн нь эрэгтэй, эмэгтэй хүн бүр аль ч шатны боловсрол эзэмших эрхтэй талаар тухайлан хуульчилсан байна.

Боловсролын тухай хуулийн 42.1.дүгээр зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.1.3 дугаар зүйлүүдэд боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх болон бүх шатны боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох, мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх, бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна хэмээн тус тус заасан байдаг.

Дээрх хууль тогтоомжоос гадна “Алсын хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого; “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”; болон “Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн үзэл баримтлал” гэх бодлогын баримт бичгүүд дээд боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг хангахад хүчин төгөлдөр үйлчилж байна.

- Нийт оролцогчдын гэр бүлийн гишүүдээс хоёроос доошгүй хүн нь дээд боловсрол эзэмшсэн хувь 31.4 байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын эхийн дээд боловсрол эзэмшсэн хувь нь эцэг болон асран хамгаалагчийн хувиас өндөр байна, мөн өрхийн

орлого нэмэгдэх тусам тухайн өрхийн дээд боловсрол эзэмшсэн гишүүний тоо нэмэгдэж байна. Мөн эцгийн боловсролын түвшин хүүхдийн их, дээд сургуульд сурах асуудалд төдийлөн хамааралгүй боловч Монголын ард түмний боловсролыг дээдлэх, үр хүүхдээ өөрсдөөсөө илүү мэдлэг боловсролтой, нийгэмд хэрэгтэй хүн болгох гэсэн хүсэл эрмэлзэл өндөр болохыг харуулж байна.

2. Судалгаанд оролцогчид нь ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхалтад өртөж байсан ба тэргүүн шалтгаанууд нь гадаад дүр төрх, хот хөдөөгийн ялгаа, үндэс угсаа зэрэг байна. *Их, дээд сургуулийн орчинд ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, багш, оюутан ажилчдад мэдээлэл хүргэх, сургалт орох, бодлогоор дэмжин ажиллах нь зүйтэй.*

Судалгаанд оролцогчдын ихэнх 66.2 хувь нь нийгмийн гарал үүсэл тэдний суралцах үйл явцад нөлөөлдөггүй хэмээн үзсэн ба эсрэгээр нөлөөлдөг гэж үзэж буй хүмүүс нь нийгмийн давхаргын ялгаа үүсгэх, багш нарын үнэлгээнд, хандлагад, мөнгөтэй эсэх, хөдөө, орон нутаг, гадаад төрх зэргийн шалтгаан болж байна хэмээн үзсэн бол үлдсэн хувь нь энэ талаарх мэдээлэлгүй байна.

3. Хөгжлийн бэрхшээл

Нийт судалгаанд оролцогч оюутнуудын 32.9 хувь нь тэдний суралцаж буй сургуульд хөгжлийн бэрхшээлтэй оюутан хариуцсан тусгай мэргэжилтэн байхгүйн дээр багш хичээлээ заахдаа тусгай хэрэгцээт оюутнуудад тохируулан заадаггүй хэмээн 26.5 хувь нь үзсэн ба их дээд сургуулийн боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй оюутан хүртэх боломж нь дээрх шалтгааны улмаас тэгш бус байдлыг үүсгэж байна. Мөн судалгаанд оролцож буй оюутнуудын дунджаар 10 орчим хувь нь энэ талын мэдээлэл дутмаг байна. *Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын тусгай хэрэгцээнд нийцүүлсэн орчныг бэлдэх, багш нарыг чадавхжуулах, сургах, оюутанд мэдээлэл хүргэх ажлыг дээд боловсролын байгууллагын удирдлага болон засгийн газар хамтран хэрэгжүүлэх.*

4. Боловсролын тэгш хүртээмжтэй байдал

Тэтгэлгийн талаарх мэдээллийг нийт судалгаанд оролцогчдын 40 орчим хувь хүртээмжгүй байдаг хэмээсэн ба оюутнуудын холбоо, клубээс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээллийг 10.2 хувь нь мөн хүртээмжгүй хэмээн үнэлсэн ба дээрх мэдээллийг нийтэд нээлттэй хүргэх тодорхой хэмжээний тогтолцооны гажуудал буйг илтгэж байна. Түүнчлэн орон нутаг дахь их дээд сургуулийн элсэлтийн хяналтын тоог судалгаанд оролцогчдын 15.2 хувь нь хүртээмжтэй гэж үнэлсэн бөгөөд талаас илүү хувь нь энэ талын мэдээлэлгүй байна. *Иймээс их дээд сургуулиуд цаашид тэтгэлэг болон түүний шалгуур, шалгаруулалтыг зохистой хүртээмжтэйгээр оюутнуудад хүргэх нь зүйтэй.*

Судалгаанд оролцогчдын 69 орчим хувь нь сургалтын төлбөрөө эцэг эхийн цалингаар төлдөг ба нийт оюутнуудын 9.3 хувь нь сургалтын төлбөрөө төлөх боломжгүйгээс шалтгаалан нэг жил өнжин суралцаж байсан ба 22.9 хувьд нь сургалтын төлбөрөө төлөх нь хүндрэлтэй, 21.9 хувьд нь асуудалгүй байжээ. Мөн оюутнуудын хаана, хэнтэй амьдарч буйгаас үл хамааран суралцаж байх хугацаанд гардаг хоол, түрээс зэрэг нэмэлт зардлыг төлөхөд хүндрэлтэй байдаг байна.

Нийт оюутнуудын хувьд цаашид дээд боловсрол эзэмших явцад тулгарч буй хүндрэлүүдийн тэргүүлэх шалтгаанд санхүүгийн хүндрэл, сурах бичгийн үнэ, ажлын ачаалал, хичээлийн хуваарийн тохироо зэрэг орж байна.

Эх сурвалж

Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль (1992). <https://legalinfo.mn/mn/detail/367>
- Боловсролын тухай хууль (2002) <https://legalinfo.mn/mn/detail/9020>
- Дээд боловсролын тухай хууль (2002) <https://legalinfo.mn/mn/detail/251>
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016) <https://legalinfo.mn/mn/detail/11711>
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) <https://legalinfo.mn/mn/detail/253>
- Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм (2007) <https://legalinfo.mn/mn/detail?lawId=204919&showType=1>
- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02-р сарын 05-ны өдрийн Дугаар 19 Тогтоол, Хавсралт 1 “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207105&showType=1>
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05-р сарын 13-ны өдрийн Дугаар 52 Тогтоол, Хавсралт 1 “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хөгжлийн бодлого. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1>
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02-р сарын 16-ны өдрийн Дугаар 42 Тогтоол “Гурван тулгуурт хөгжлийн бодлого батлах тухай” <https://legalinfo.mn/mn/detail/13240> -аас хамгийн сүүлд 2023.06.13-ны өдөр хандав.
- Монгол Улсын Их Хурлын 2001 оны 06-р сарын 14-ний өдрийн Дугаар 57 Тогтоолын Хавсралт “Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Үзэл Баримтлал”. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=203158&showType=1>

Ном бүтээл

- UN DESA, Sustainable Development Goals, Goal 4. <https://sdgs.un.org/goals/goal4>
- UNESCO (2016) Global Education Monitoring Report, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000245752>
- Stanford University, Equality of Opportunity and Education. <https://edeq.stanford.edu/sections/section-3-equality-opportunity-and-education/higher-education>
- Карин Шелциг, Кирсти Ньюман (2020) Монгол Улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь, АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн цуврал тайлан Дугаар 28. <https://www.adb.org/mn/publications/promoting-inclusive-education-mongolia>
- ЮНЕСКО (2019) Монгол улсын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687_mon
- UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education,

- p.11. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf>
- ХЭҮК, Хүний эрхийн олон улсын билл: Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл, УБ., 2019 он.
 - Адам Свифт, Улс төрийн философи, Эрх зүйт ёс сан, УБ., 2014 он.
 - Tristan McCowan, Three Dimensions of Equity of Access to Higher Education, Compare (2016), 46(4).https://www.researchgate.net/publication/281221321_Three_dimensions_of_equity_of_access_to_higher_education
 - UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education, p.11. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf>
 - UNESCO Institute for Statistics (2018) Handbook on Measuring Equity in Education, p.30. <http://uis.unesco.org/sites/default/files/documents/handbook-measuring-equity-education-2018-en.pdf>
 - Mega Wanti, Renate Wesselink, Harm Biemans and Perry den Brok (2022) Determining factors of access and equity in higher education: A systematic review, Equity in Education & Society Vol. 1(2) 279–296. <https://journals.sagepub.com/doi/pdf/10.1177/27526461221092429>
 - Дээд боловсролын 2022-2023 оны статистик. https://www.meds.gov.mn/posts?category_id=11403
 - Баяржаргалын Цог, Орон нутгийн их, дээд сургуулиудын элсэлтийн байдал, бодлогын зорилт, хэрэгжилт, УБ., 2020 он. 1 дэх тал. <https://higher-education-new-era-journal.mn/assets/front/images/pdf/articles/914b3z7Aac1VQmSMrBpMdSFRlcS1QMUAk6cGc6JH.pdf>
 - UNESCO (2020) Quality Assurance and Recognition of Distance Higher Education and TVET, COVID-19 Education Response Education Sector issue notes. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373754>
 - Julie A. Willems, Chris Campbell, Helen Sara Farley (2019) The Increasing Significance of Digital Equity in Higher Education: An Introduction to the Digital Equity Special Issue, Australasian Journal of Educational Technology 35(6). https://www.researchgate.net/publication/338263351_The_increasing_significance_of_digital_equity_in_higher_education_An_introduction_to_the_Digital_Equity_Special_Issue
 - Right to Education, Covid-19 and technical difficulties: the rise of inequalities in higher education. <https://www.right-to-education.org/blog/covid-19-and-technical-difficulties-rise-inequalities-higher-education>
 - UNESCO Education Policy Review: Towards a Lifelong Learning System (June 2020), <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687/PDF/373687eng.pdf.multi>

